# *ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ*

**/Судалгааны тайлан/**

**ЗАХИАЛАГЧ:** **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

**ГҮЙЦЭТГЭСЭН:** **Б.БАТЦЭЦЭГ**

**Улаанбаатар хот**
**2019 он**

## ГАРЧИГ

**Өмнөтгөл**

Үнэлгээний зорилго
Үнэлгээ хийхэд баримтлах зарчим

**Нэг.Төлөвлөх үе шат**

1.1.Үнэлгээ хийх шалтгаан;
1.2.Үнэлгээний хүрээг тогтоох нь;
1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох;
1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

**Хоёр.Хэрэгжүүлэх үе шат**

**Гурав.Үнэлэх үе шат**

3.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Гуравдугаар бүлэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг Монгол Улсад орогнох эрх олгохтой холбоотой зохицуулалтын үнэлгээ;

3.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Гуравдугаар бүлэг, 10 дугаар зүйл буюу Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэгтэй холбоотой зохицуулалтын үнэлгээ;

3.3.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу Монгол Улсын.визийн талаарх зохицуулалтыг үнэлгээ;

3.4.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Тавдугаар бүлэг, 22 дугаар зүйл буюу Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх талаарх зохицуулалтын үнэлгээ;

3.5.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Зургадугаар бүлэг буюу Гадаадын иргэний бүртгэлийн талаарх зохицуулалтын үнэлгээ;

3.6.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйл буюу Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх талаарх зохицуулалтын үнэлгээ;

3.7.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйл буюу Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах талаарх зохицуулалтын үнэлгээ.

**Дөрөв. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

# ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## ӨМНӨТГӨЛ

Монгол Улс нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөн ардчилсан шинэ үндсэн хуулиа 1992 онд батлсны дараагаар бусад хууль, эрх зүйг шинэчлэх эх давалгаа явагдсан бөгөөд үүний нэг нь гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух харилцаа болон тэдний эрх үүргийг тогтоосон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 1993 онд анх баталсан байна.

1993 онд батлагдсан дээрх хуулиар Монгол Улсын виз, тус улсад орох, гарах, дамжин өнгөрөх журам, виз олгох байгууллагын эрх, үүрэг үндэслэл, Монгол Улсад орох, орохыг үл зөвшөөрөх үндэслэл, гарах, гарахыг түдгэлзүүлэх тохиолдол, албадан гаргах тухай зохицуулалт болон хууль тогтоомжид зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуулиар хариуцлага хүлээгэх ерөнхий заалтыг тусгасан байна.

2010 онд Монгол Улсын Их Хурлаас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль нь гадаадын иргэдэд оршин суух цахим үнэмлэх олгох асуудлыг шинээр тусгаж, шаардлагагүй зарим зориулалтын буюу “гарах” визийг олгохыг зогсоож, зөрчил гаргасан гадаадын иргэнийг шүүхийн шийдвэрээр түр саатуулах болон түр саатуулах байр орон нутагт ажиллах эрх зүйн орчинг бий болгосон болно. Мөн хуулиар хариуцлагын тогтолцоог тодорхой болгон хууль тогтоомж зөрчсөн этгээдэд оногдуулж байсан захиргааны шийтгэл буюу торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн нь гадаадын иргэн болон тэдгээрийн уригчийг хариуцлагажуулахад тодорхой дэмжлэг үзүүлсэн болно.

Дэлхий нийтийг хамарсан шилжилт хөдөлгөөний их урсгалд нийцүүлэн улс орон бүхэн шилжилт хөдөлгөөний талаар баримталж буй бодлогоо өөрчлөх, техник технологийн ололтыг шилжилт хөдөлгөөнд ашиглах замаар гадаадын иргэдэд виз, оршин суух, бүртгэлийн талаарх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ нөгөө талаас улс орны дотоодын аюулгүй байдлыг хамгаалах гэсэн хоёр ойлголтын уулзварыг тэнцвэртэй хангахыг зорьж байна.

Дэлхийн улсуудын шилжилт хөдөлгөөний байгууллагуудын үндсэн зорилго бол тухайн улс оронд шаардлагатай, хүсэл зорилгоо илэрхийлсэн гадаадын иргэд дундаас сонголт хийн зохих визийг олгон, өөрийн орны иргэдэд ногдох түр болон удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэдийн зөв, зохистой харьцааг тогтоох замаар эдийн засаг, нийгмийн өсөлтийг бий болгох явдал юм. Гэвч гадаадын иргэд хууль бусаар оршин суух нь нэмэгдэж байвал тухайн орны шилжилт хөдөлгөөний талаарх бодлого бүрэн хэрэгжиж чадахгүй байна гэж үзэж болохоор байна. Түүнчлэн тухайн орны газар зүйн байршил, хүн амын орлогын төвшин, хөдөлмөрийн болон шилжилт хөдөлгөөний

бодлогын уялдаа холбоо болон бодлогыг хэрэгжүүлэх чадамж нь чухал ач холбогдолтой юм.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхлээд 9 жил болж байгаа боловч Монгол Улс гадаадын иргэдийн орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух харилцааг зохицуулж буй хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгааг бодлогын баримт бичигт тусгасан байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 161-д “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, хүсэлтийг буцаах үндэслэл зэрэг асуудлаар журам батлах эрхийг эрх бүхий этгээдэд олгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна” гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.12-т “Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна” гэж, мөн хөтөлбөрийн 4.4.4-т “хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөрш орнуудтай хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ, маршрутыг хөгжүүлэх” гэж, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх замаар 2020 он гэхэд Монголд аялах гадаадын жуулчдын тоог 1 саяд, 2030 он гэхэд 2 саяд хүргэх зорилт дэвшүүлсэн.

Иймээс энэхүү үнэлгээний зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн[1] 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын эерэг, сөрөг талуудыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016

[1] Монгол Улсын Их Хурал 2015 онд батлаж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлэхэд оршино.

**Үнэлгээний зорилго нь**

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, түүний өнөөгийн байдлыг судлан тогтоож, хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, үүн дээр үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн чиглэлийн талаар санал, зөвлөмж боловсруулан хууль санаачлах эрх бүхий холбогдох байгууллага буюу судалгааг захилагч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх явдал юм.

- **Үнэлгээ хийхэд баримталсан зарчим:**

Үнэлээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглах замаар хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасны дагуу дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд үнэлгээ хийх шалтгаан нь хуулийн зохицуулалт нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэгжилтийн байдал эерэг үр дүн үүсгэж байгаа эсэх, Монгол Улсын виз, оршин суух, бүртгэл нь гадаадын иргэдэд ойлгомжтой, хүндрэл үүсгэхээргүй зохицуулагдаж чадсан эсэх болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой эсэх, дэлхийн улс орнуудын чиг хандлагад нийцсэн эрх зүйн зохицуулалт хуульд тусгагдсан эсэхийг тогтоох замаар хуулийг шинэчлэн найруулах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг илрүүлэх явдал юм.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төсөл боловсруулахад хуулийн хэрэгжилтийн үр

дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төслийг боловсруулахаар зохицуулсан нь үнэлгээ хийх шалтгаан юм.

### 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох нь

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг үнэлэхээр үнэлгээний хүрээг тогтоож байгаа бөгөөд үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| д/д | Үнэлэгдэх бүлэг | Үнэлэгдэх зүйл, хэсэг |
|---|---|---|
| 1 | Хуулийн Гуравдугаар бүлэг | 9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно. |
| 2 | Хуулийн Гуравдугаар бүлэг | **10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг**<br>10.1.Гадаадын иргэнийг Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:<br>10.1.1.гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад бүртгүүлэх;<br>10.1.2.гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаа гаргах;<br>10.1.3.Монгол улсын виз, оршин суух зөвшөөрлийнх нь хугацаанд гадаадын иргэнийг буцаах.<br>10.2.Энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааны төрөл, хэлбэр, тэдгээрийг мэдүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна. |
| 3 | Дөрөвдүгээр бүлэг Монгол Улсын вмз | 11 дүгээр зүйлээс 20 дугаар зүйл |
| 4 | Тавдугаар бүлэг Монгол Улсад орох, дамжин өнгөрөх | **22 дугаар зүйл.Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх**<br>22.1.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө:<br>22.1.1. 16 насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй гадаадын иргэн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол;<br>22.1.2.Монгол Улсад ял шийтгүүлсний дараа тус улсаас гарсан бөгөөд ялгүйд тооцох хугацаа нь дуусаагүй бол;<br>22.1.3.Монгол Улс тааламжгүй этгээд гэж зарласан бол;<br>22.1.4.олон улсын хэмжээнд эрэн сурвалжилж байгаа бол; |

| | | |
|---|---|---|
| | | 22.1.5.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахад харшилж байвал;<br><br>22.1.6.Монгол Улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй бол;<br><br>22.1.7.энэ хуульд заасан журмын дагуу албадан гаргасан бөгөөд Монгол Улсад орохыг хориглосон хугацаа дуусаагүй бол. |
| 5 | Зургадугаар бүлэг Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух | **24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх**<br>24.1.Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.<br><br>*/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/*<br>24.2.Гадаадын иргэнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг бүртгүүлэх үүргийг хүлээнэ.<br><br>24.3.Энэ хуулийн 24.2-т зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.<br><br>24.4.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.<br><br>*24.5.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаад улсын иргэнийг бүртгэхдээ татвар төлөгчийн дугаарыг олгоно. Татвар төлөгчийн дугаарын тоон агуулга, хэлбэрийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно.*<br><br>**26 дугаар зүйл.Гадаадын иргэний хаягийн бүртгэл**<br>26.1.Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ.<br><br>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан гадаадын иргэн оршин суугаа хаягаа өөрчилбөл анх бүртгүүлсэн газартаа мэдэгдэн хасалт хийлгэж, |

| | | |
|---|---|---|
| | | шилжин очсон сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад 14 хоногийн дотор хаягийн бүртгэл хийлгэнэ. |
| 6 | Долдугаар бүлэг Монгол Улсаас гарах | **34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх**<br>34.1.Гадаадын иргэн Монгол Улсад байхыг зөвшөөрсөн хугацаанд багтаж тус улсаас гарна.<br>34.2.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:<br>34.2.1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл;<br>34.2.2.шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;<br>34.2.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол.<br>34.3.Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана.<br>34.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ. |
| 7 | Долдугаар бүлэг Монгол Улсаас гарах | **37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах**<br>37.1.Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараахь үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:<br>37.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;<br>37.1.2.оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;<br>37.1.3.түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;<br>37.1.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан; |

| | | |
|---|---|---|
| | | 37.1.5.Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон;<br><br>37.1.6.хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;<br><br>37.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;<br><br>37.1.8.энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;<br><br>37.1.9.нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;<br><br>37.1.10.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;<br><br>37.1.11.шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьялах улсад нь шилжүүлэхээр болсон;<br><br>37.1.12.түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн.<br><br>37.2.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана. |

### 1.2.Шалгуур үзүүлэлтийг тогтоох

Өмнөх үе шатанд үнэлгээ хийхээр сонгосон Гадаадын иргнэий эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтооход туслах, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж, тогтоож чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

Хүснэгт 2

| д/д | Үнэлэгдэх бүлэг | Үнэлэгдэх хэсэг, заалт | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|
| 1 | Хуулийн Гуравдугаар бүлэг | 9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно. | Зорилгод хүрсэн байдал.<br><br>Практикт нийцэж байгаа байдал. |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Гуравдугаар бүлэг | 10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал |
| 3 | Дөрөвдүгээр бүлэг Монгол Улсын вмз | 11 дүгээр зүйлээс 20 дугаар зүйл | Практикт нийцэж байгаа байдал. |
| 4 | Тавдугаар бүлэг Монгол Улсад орох, дамжин өнгөрөх | 22 дугаар зүйл.Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал |
| 5 | Зургадугаар бүлэг Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух | 24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх<br><br>26 дугаар зүйл.Гадаадын иргэний хаягийн бүртгэл | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал |
| 6 | Долдугаар бүлэг Монгол Улсаас гарах | 34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал |
| 7 | Долдугаар бүлэг Монгол Улсаас гарах | 37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал |

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, заалтын “хэрэгжилтийг хамгийн оновчтойгоор илэрхийлэн гаргаж чадах” гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухай хуулийн зохицуулалтад төдий л ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

### 1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цугуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаанд үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо бармит нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистик, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэрэг байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Хүснэгт 3

| д/д | Үнэлэгдэх зүйл | Шалгуур үзүүлэлт | Харьцуулах хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | 9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно. | Зорилгод хүрсэн байдал.<br><br>Практикт нийцэж байгаа байдал. | Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |
| 2 | 10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |
| 3 | 11 дүгээр зүйлээс 20 дугаар зүйл | Практикт нийцэж байгаа байдал. | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |
| 4 | 22 дугаар<br>зүйл.Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |
| 5 | 24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх<br><br>26 дугаар зүйл.Гадаадын иргэний хаягийн бүртгэл | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |
| 6 | 34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | 37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи |

### 1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхмууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Хүснэгт 4

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Харьцуулах хэлбэр | Шалгуур үзүүлэлтийн томьёолол |
|---|---|---|---|---|
| 1 | 9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно. | Зорилгод хүрсэн байдал.<br><br>Практикт нийцэж байгаа байдал. | Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Монгол Улсад орогнох эрх олгох талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай бөгөөд тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх? |
| 2 | 10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Хуулиар гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүлээлгэсэн үүрэг нь оновчтой эсэх?<br>Уг үүрэг нь гадаадын иргэний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгыг хангаж чадаж байгаа эсэх? |
| 3 | Хуулийн 11 дүгээр зүйлээс 20 дугаар зүйл Монгол Улсын визийн талаарх зохицуулалт | Практикт нийцэж байгаа байдал. | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Монгол Улсын визийн талаарх зохицуулалт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болон гадаадын иргэдэд ойлгомжтой, хүндрэлгүй байж чадаж байгаа эсэх?<br>Монгол Улсын визийн талаарх зохицуулалт нь олон улсын жишигт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | болон Монгол Улсын аялал жуулчлалын талаар баримталж буй бодлогод нийцэж буй эсэх? |
| 4 | 22 дугаар зүйл.Монгол Улсад орохыг ү л зөвшөөрөх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх зохицуулалт нь практикт бүрэн нийцэж буй эсэх?<br><br>Уг зохицуулалтын нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? |
| 5 | 24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх<br><br>26 дугаар зүйл.Гадаадын иргэний хаягийн бүртгэл | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Гадаадын иргэний бүртгэл нь хүндрэлгүй бөгөөд практикт бүрэн нийцэж буй эсэх?<br><br>Олон улсын чиг хандлагын дагуу гадаадын иргэдийн бүртгэлийг хийхэд хуулийн зохицуулалт нь хангалттай эсэх? |
| 6 | 34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Гадаадын иргэдийг гарахыг түдгэлзүүлэх үндэслэл нь практикт нийцэж буй эсэх? |
| 7 | 37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах | Практикт нийцэж байгаа байдал.<br><br>Зорилгод хүрсэн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи | Гадаадын иргэдийг албадан гаргах зохицуулалтыг хэрэглэхэд хүндрэл тулгарч байгаа эсэх? |

### 1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн өмнөх алхам /үнэлгээний шалтгаан, хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг тогтоох, шалгуур үзүүлэлтийг томьёолох/-уудаа ямар тохиодолд тоон, ямар тохиолдолд чанарын мэдээллийг ямар аргаар цуглуулахаа энэ үе шатанд сонгоно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ мэдээлэл цуглуулах дараах аргыг ашиглана. Үүнд:

- Хууль хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай танилцах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах /Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаадын иргэн, харьяатын газар, бусад/
- Дээрх байгууллагуудын тайлан, статистикийг ашиглах
- Гадаадын иргэнийг уригч, ажиллуулагч, хамтран ажиллагч зэрэг гадаадын иргэнтэй холбоотой төрийн үйлчилгээг авдаг иргэн, хуулийн этгээдтэй уулзах, холбогдох судалгааны бүтээл зэргийг судлах замаар үнэлгээг хийхэд ашиглах холбогдох чанарын болон тоон мэдээлийг цуглуулна.

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2019 оны 08 дугаар сарын 25-наас 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагуудтай уулзалт ярилцлага хийж, холбогдох тоо баримт, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэргийг судалж Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиас сонгож авсан үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

### 3.1.ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛИЙН 9 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 9.1.МОНГОЛ УЛСАД ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛДЭГ ҮЗЭЛ САНААНЫ ТӨЛӨӨ ХАВЧИГДАН МӨШГӨГДСӨН ГАДААДЫН ИРГЭНД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ТУС УЛСАД ОРОГНОХ ЭРХ ОЛГОНО.

Хүснэгт 5

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 “Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно.” |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Монгол Улсад орогнох эрх олгох талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай бөгөөд тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх? |

**Үнэлгээ:**Монгол Улс чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэнээр хүн бүр чөлөөтэй гадаад улсад зорчих болж, нөгөө талаас гадаадын улсын харьяат иргэдийн манай улсад ирэх урсгал нэмэгдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг, Арван наймдугаар зүйлийн 4-т “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 9/-д Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;” гэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4-т “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно.” гэж тус тус заасан байна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад орогнох эрх олгох эрхийг хууль тогтоомжоор Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон боловч уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ямар нөхцөл, шаардлагыг хангасан этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгох болон тэдгээр иргэд нь Монгол Улсад ямар статусаар оршин суухыг журамласан эрх зүйн зохицуулалт манай улсад байхгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 89 дүгээр зарлигын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 2.1.15-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.” гэсэн боловч хууль тогтоомжид ямар журам заасан нь мөн л тодорхойгүй байна.

Иргэний харьяалал нь нийгэм - эрх зүйн хоёрдмол үүргийг гүйцэтгэдэг. Нэг талаас төр өөрийн иргэний эрхийг хамгаалах арга хэрэгсэл болгодог бол нөгөө талаас төр, нийгмийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болгодог байна. Иргэний харьяаллын мөн чанар нь харьяатын адил төрийн мөн чанараар тодорхойлогддог. Боолын нийгмийн үед боолын эзэн иргэн нь – өмч хөрөнгөтэй, хувь хүнийхээ хувьд чөлөөт, онцгой эрхтэй байдлаар тодорхойлогддог байсан бол феодалын нийгэмд - улсынхаа тэргүүнд буюу хувь хүнд хамаарах байдлаар, хөрөнгөтний нийгэмд - төрийн засаглалын хэрэгт иргэн оролцох тэгш эрхийг ёс төдий илэрхийлсэн байдлаар тодорхойлогдоно. Иргэний харьяалал нь төрийн тусгаар тогтнолтой шууд холбоотой. Энэ нь нэгдүгээрт: төр нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд иргэний эрх зүйн байдлыг зохицуулдаг. Энэ тохиолдолд иргэний харьяаллыг хуульчлах замаар түүний дээд хүчин чадлыг тогтоодог. Хоёрдугаарт: тухайн иргэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, тухайлбал, төрийн тусгаар тогтнолын баталгаа болдог. Гэтэл харьяалсан улс нь тухайн иргэнийг үзэл бодлынх нь төлөө хавчин гадуурхах тохиолдол байдаг бөгөөд энэ тохиолдолд тухайн иргэний харьяат биш улсын зүгээс уг иргэнийг өөрийн улсад орогнол олгох замаар хамгаалах тохиолдол гардаг болно.

Иргэний харьяаллыг чөлөөтэй, сайн дураар сонгох эрхийн зарчим байдаг бөгөөд энэ зарчмын гол агуулга нь хувь хүн иргэний харьяалалтай болох, иргэний харьяаллаа дуусгавар болохтой холбоотой асуудлыг өөрөө бие даан шийдэх явдал юм. Хэн ч эрх зүйн бүрэн чадамжтай этгээдийг албадан иргэний харьяаллыг нь өөрчлөхийг шаардах эрхгүй байдаг. Иргэний харьяалал нь төр, хувь хүн хоорондын тогтвортой харилцаа болохынхоо хувьд хүнийг хүч хэрэглэн, албадан иргэний харьяаллыг нь өөрчлөх асуудал гаргуулахгүй байх зарчимтай.

Иргэний харьяаллыг хамгаалах үүднээс иргэний харьяаллаас хасахгүй байх зарчим байх ба иргэний харьяалал дуусгавар болох гэдэг ойлголтод иргэний харьяаллаас гарах, иргэний харьяаллаас хасах буюу алдах ойлголтыг хамруулдаг. Иргэний харьяаллаас гарах гэдэгт тухайн иргэн өөр улсын иргэний харьяалалтай болох зорилгоор сайн дурын хүсэл зоригоо илэрхийлж өөрийн улсын иргэний харьяаллаас гарч байгаа хэрэг. Иргэний харьяаллаас хасахгүй байх зарчмыг улс бүр өөр өөрийнхөөр шийдвэрлэдэг. Тухайлбал Эстони Улсын Үндсэн хуульд төрснөөр тус улсын иргэний харьяалалтай болсон иргэнийг тус улсын иргэний харьяаллаас хасахыг хориглосон заалт байдаг нь бусад хэлбэрээр тус улсын иргэний харьяалалтай болсон иргэдийг шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгаа гэж үзэж болох юм. Латви, Литви Улсын хуульд энэ талын заалт огт тусгагдаагүй байна.

Иргэний харьяаллаас хасах Иргэний харьяаллын асуудлаар гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, иргэний харьяаллаас хасах хоёр нь хоорондоо харилцан холбоотой ойлголт билээ. Энэ нь нэгдүгээрт: хувь хүний санаа зоригийн илэрхийлэлгүй иргэний харьяаллыг дуусгаж байгаа ганц үндэслэл, хоёрдугаарт: олон оронд хууран мэхлэх замаар иргэний харьяалалтай болсон бол түүнийг хүчингүй болгодог нь хэвийн үзэгдэл. Иргэний харьяаллаас хасах нь тухайн хүний саналыг харгалзахгүй зөвхөн нэг талын саналаар холбоог таслаж байгаа хэрэг юм.

Хүний эрхийн баримт бичигт иргэнийг харьяаллаас хасч болохгүй тухай заасан хэдий ч ардчилсан үзэлтэй олон оронд, тухайлбал, Испани Улсын Үндсэн хуульд “нэг ч Испани гаралтай хүн үндэстнээсээ хасагдах ёсгүй” гэж заасан нь хүсэлтээрээ Испаний иргэний харьяалалтай болсон хүнд хамаарахгүй. Мөн Австрийн хуульд өөрийн хүсэлтээр тус улсын иргэний харьяалалтай болсноос хойш 6 жилийн хугацаанд иргэний харьяаллаас хасахыг хориглосон заалт байдаг байна. Иргэний харьяаллаа алдах Олон орны хуульд иргэний харьяаллаа алдах үндэслэлийг өөрийн орны түүх, улс төр, эдийн засгийн болон бусад нөхцөлийн улмаас янз бүрээр тусгасан байдаг.

Тухайлбал АНУ-д: эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгний болон өөрийн хүсэлтээр (натурализаци) өөр улсын иргэний харьяалалтай болсон, өөр улсын улс төрийн болон бусад байгууллагад тухайн улсад үнэнч гэдгээ тангарагласан, эсхүл ямар нэгэн байдлаар илэрхийлсэн, тус улсын Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайдын тусгай зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөр улсын зэвсэгт хүчинд алба хаасан, өөр улсын иргэний харьяалалтай болохоор тухайн улсын засгийн газрын болон улс төр- орон нутгийн байгуулагад албан тушаал хашсан, Иргэний харьяаллаасаа татгалзахаар эрх бүхий албан тушаалтанд бичгээр хүсэлтээ гаргасан, АНУ-ын засаг, төрийн эсрэг зэвсэгт хүчин, бусад хүч хэрэглэсэн үйл ажиллагаанд оролцсон бол АНУ-ын иргэний харьяаллыг алдах үндэслэл болдог.[2]

Орогнол хүсэгчийн тухайд иргэний харьяаллаа алдаагүй болон алдсан аль ч тохиолдол үүсэх боломжтой ба үүнийг эрх зүйн хувьд өөрийн иргэний харьяалалтай эсвэл оршин суугаа орондоо улс төрийн шалтгаанаар хавчигдан мөшгигдөж байгаа хүн өөр улсад орох эрх олгохыг хүсэж өргөдөл гаргахыг **орогнох эрх** гэдэг. Улс төрийн шалтгаан гэдэгт дан ганц улс төрийн үзэл бодол биш, шашин шүтлэг, шинжлэх ухааныг үзэх үзэл, үйл ажиллагаа, арьсны өнгө, үндэс угсаагаар гадуурхахыг хэлдэг байна. ОРОГНОХ ЭРХ нутаг дэвсгэрийн (аль нэг улсын газар нутаг дээр орогнох) дипломат (ДТГ-ын болон консулын газрын байранд орогнох) гэсэн хэлбэртэй байдаг. Орогнох эрх олгох асуудлыг улсуудын үндэсний хууль тогтоомжоор зохицуулах ба олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр орогнол олгосон улсыг бусад улс нь хүндэтгэн үзэх зарчимтай.

---

[2] “Иргэний харьяалал ба шилжилт хөдөлгөөн” Б.Амарсанаа, Х.Гэрэлчулуун нар, 2013 он

Орогнох эрхийн үр дагавар нь

1. Улс төрийн шалтгааны улмаас хэн нэгэнд орогнох эрх олгосон бол түүнийг өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

2. Хилийн чанадад орогногчийн эрх хөндөгдсөн тохиолдолд орогнол олгосон улс дипломат хамгаалалт үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, орогногч түр хугацаагаар гуравдагч улсад зорчих явцад эрх нь зөрчигдөх асуудал юм.

3. Орогнол олгосон улс тухайн орогногчийн үйл ажиллагааны өмнөөс хариуцлага (хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох үүрэгтэй) хүлээнэ.

Орчин үед олон улсын эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн орогнох эрхийн тухай акт, гэрээ, хэлэлцээр байхгүй бөгөөд энэ асуудал гол төлөв үндэсний хэм хэмжээгээр зохицуулагддаг. Энэ нь хүн бүр улс төрийн болон бусад шалтгааны улмаас өөр улсад орогнох эрх хүсэх эрхтэй, Улс бүр өөрийн бүрэн эрхийн хэмжээнд үндэсний хууль тогтоомждоо орогнох эрх олгох журмыг тогтоох, Орогнох эрх олгох нь улс хооронд дайсагнасан хэрэг биш хүмүүнлэгийн шинжтэй гэдгийг ухамсарлах, орогнол хүсэгч мөрдөн мөшгигдөж байгаа улсдаа цөллөгдөхгүй байх, олон улсын гэмт хэрэгтэн болон эрүүгийн хэрэгт яллагдагчид орогнох эрх олгохгүй байх зэрэг орогнох эрхтэй холбоотой ерөнхий зарчмууд байдаг байна.

Орогнол олгох асуудлыг НҮБ-ын Орогнох нутаг дэсгэрийн тухай тунхаг (1967 он), Европын Холбооны Орогнох нутаг дэсгэрийн тухай тунхаг (1977 он), Орогногчийн тухай Гаваны конвенц (1928 он), Дипломат орогнолын тухай конвенцид (1954 он) зэрэгт тус тус тусгагдсан байна.

Монгол Улс орогнох эрх олгохоор хуульд заасан боловч нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Монгол Улсад орогнох эрх олгохыг хүссэн тохиолдол гарсан эсэх талаар Гадаадын иргэн, харьяатын газар болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын холбогдох албан хаагчаас тодруулахад тийм тохиолдол гараагүй талаар дурдсан болно.

Шигтгээ:
2019 оны 4 дүгээр сард Бүгд найрамдах Турк улсын Элчин сайдын яамнаас Монгол Улсын Гадаад харилцааны яамаар дамжуулж бичиг ирүүлсэн. Уг бичигт Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа “Эмпати” сургуулийн БНТУ-ын харьяалалтай долоон багш, монгол иргэнтэй гэр бүл болсон нэг иргэний гадаад паспортуудыг хүчингүй болгосон бөгөөд тэдгээр иргэдийг нэн даруй өөрийн улсаас алдан гаргаж БНТУ-д шилжүүлж өгөхийг мэдэгдсэн байсан. Өөрөөр хэлбэл, Турк улс өөрийн иргэдийн паспортыг хүчингүй болгосон бичиг ирүүлсэн байна.
Уг асуудалд Монгол Улс хэрхэн хандсан процессыг тоймловол
“Тэдгээр БНТУ-ын харьяат найман иргэний хувьд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зорилгоор орж ирсэн. Оршин суух зөвшөөрөлтэй уг зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байсан.

> БНТУ-ын Элчин сайдын яамнаас ирүүлсэн албан бичгийн хариуд Монгол Улсын эрх бүхий байгууллагаас Гадаад харилцааны яамаар дамжуулж уламжлаад эдгээр иргэдийг албадан гаргах хууль, эрх зүйн үндэслэл байхгүй талаар хариу өгсөн байна.
>
> Нэгэнт бид дээрх найман иргэнд оршин суух зөвшөөрөл өгсөн учир одоо үүсээд байгаа нөхцөл байдлыг тайлбарлах ёстой. Тиймээс бид эхний ээлжид “Эмпати” компанийн захирал Б.Ганбат гэж хүнийг урьж уулзсан.
>
> Уригч байгууллагын хувьд танай сургуульд багшилж байгаа багш нартай холбоотой ийм бичиг ирсэн, энэ хүмүүсийн бичиг баримтыг харьяалах улсын эрх бүхий байгууллага хүчингүй болгосон байна, энэ талаар багш нартаа мэдэгдэхийг зөвлөсөн. Мөн бичиг баримтынхаа зөрчлийг арилгах шаардлагатай учраас Монгол Улсад суугаа Туркийн Элчин сайдын яамандаа хандаж асуудлаа шийдвэрлүүлэх хэрэгтэйг хэлсэн.
>
> Үүний дараа дээрх Турк багш нар Улсын ерөнхий прокурор, Хууль зүйн яам, Хүний эрхийн үндэсний комисс гэх зэргээр хандаж болох бүх газарт хандсан байна лээ. Энэ нь аргагүй юм. Өмгөөлөгч нь мөн тэдгээр иргэдийн талаар албан бичиг өгсөн. Танай байгууллага энэ хүмүүсийн бичиг баримтыг хүчингүй болгосон шийдвэр гаргасан. Үүнийгээ тайлбарла гэсэн.
>
> Мөн хилээр гарах асуудлыг түдгэлзүүлсэн шалтгааныг тодруулахыг хүссэн. Бид өмгөөлөгч У.Батбаатарыг урьж асуудлыг хуулийн хүрээнд тайлбарлаж, дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.
>
> Гадаадын иргэнийг хилээр гарахыг түр түдгэлзүүлэх хуулийн заалт байдаг. Энэ болгоныг өмгөөлөгчид тайлбарлаж өгсөн. Яг энэ үед Туркийн нэг багш хилээр гарах орох виз авах хүсэлт гаргасан. Бид уг визийг олгохоос татгалзсан. Яагаад гэвэл Турк улс иргэндээ олгосон паспортыг хүчингүй болгосон. Тиймээс хүчингүй бичиг баримт дээр манайх виз олгож хилээр гаргаж болохгүй. Аль ч улсад ийм л байдаг. Энэ учрыг хэлсэн. Түүнчлэн, өмгөөлөгчөөс багш нарын асуудлаар Туркийн Элчин сайдын яаманд хандсан уу гэж асуусан. У.Батбаатар бидэнд “хандсан” гэж хариулсан. Гэхдээ хэзээ хандсан, хэн гэдэг хүнтэй уулзсан тухай тодруулахад хариу өгөөгүй.”
>
> Гадаадын иргэн, харьяатын газрын дарга д.Мөрөнгийн Өдрийн сонинд өгсөн ярилцлагаас 2019 оны 06 дугаар сарын 03-нд

Гадаадын иргэн, харьяатын газрын зүгээс тэдгээр найман багшийг Элчин сайдын яамандаа хандаж, хүчингүй болсон гадаад паспортын асуудлаа шийдвэрлэхийг зөвлөсөн байна. Учир нь, гадаад паспорт бол тухайн улсын өмч байдаг тул дээрх асуудлыг Элчин сайдын яам нь шийдвэрлэх ёстой гэж үзсэн байна. Гадаад паспортын асуудлаа шийдэж, зөрчилгүй бичиг баримттай болсон тохиолдолд Гадаадын иргэн, харьяатын газраас оршин суух визний хугацааг нь сунгаж өгөх, аль эсвэл гуравдагч орон руу гарахыг зөвлөжээ.

Тэдгээр иргэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс эхлээд хандаж болох бүхий л байгууллагад хандаж, асуудлыг нь шийдвэрлэж өгөхийг хүссэн боловч Монгол Улсаас оргонол хүссэн эсэх нь тодорхойгүй байна.

Монгол Улс дахь НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхлэх дээд комиссарын газраас тэдгээр хүмүүсийг оргонол хүсэгч болохыг баталж гэрчилгээ олгон, энэ хүмүүсийн хүсэлтийг шийдвэрлэх хугацаанд Монгол Улсад байлгана уу гэсэн хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсний дагуу тэдгээр иргэд Монгол Улсад 2019 оны 8 дугаар сар хүртэл байсан байна.

НҮБ-аар дамжуулан гаргасан тэдний хүсэлтийг Канад Улс зөвшөөрч, тэдгээрийг иргэдийг хүлээн авахаа мэдэгдэн аялалын бичиг баримт олгосноор дээрх иргэд 2019 оны 8 дугаар сард Монгол Улсыг орхин Канад Улсыг зорьсон байна.

Дээрх тохиодлыг судалсны учир нь дээрх иргэд нь олон улсын эрх зүй ёсоор улс төрийн оргонол хүсэгчид мөн бөгөөд манай улсаас оргонол хүссэн эсэх нь тодорхойгүй боловч хэрэв цаашид Монгол Улсаас оргонол хүсэх тохиолдол гарвал үүнийг хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт манайд байхгүй байна.

Иймд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль дахь оргонол хүсэхтэй холбоотой журмын зохицуулалт болон оргонол хүсэгчийн статусын талаар зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

### 3.2. ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 10 ДУГААР ЗҮЙЛ.ГАДААДЫН ИРГЭНИЙГ УРИГЧ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Хүснэгт 6

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | **Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг**<br>10.1.Гадаадын иргэнийг Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:<br>10.1.1.гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад бүртгүүлэх;<br>10.1.2.гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаа гаргах;<br>10.1.3.Монгол улсын виз, оршин суух зөвшөөрлийнх нь хугацаанд гадаадын иргэнийг буцаах.<br>10.2.Энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааны төрөл, хэлбэр, тэдгээрийг мэдүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна. |

| | |
|---|---|
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуй нэгж байгууллагад хуулиар хүлээлгэсэн үүрэг нь оновчтой эсэх?<br>Уг үүрэг нь гадаадын иргэний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгыг хангаж чадаж байгаа эсэх? |

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар түр ирэгчийн бүртгэлийг ажлын 7 хоногийн дотор хийхээр зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл 30-аас дээш хоногоор ирсэн иргэн Гадаадын иргэн, харьяатын газарт 7 хоногийн дотор бүртгүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд уригч иргэн, байгууллагын шугмаар ирсэн тохиолдолд уригч нь тухайн гадаадын иргэнээ бүртгүүлэх энэ үүргийг хүлээдэг байна.

Энэ зохицуулалт нь эрх зүйн ямар нэг үр дагавартай болох нь тодорхойгүй бөгөөд Монгол Улсын хилээр нэвтрэн орж ирэхэд Монгол Улсын холбогдох байгууллагад бүртгүүлж байгаа хэрнээ дахин 7 хоногийн дотор Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа нь гадаадын иргэд болон уригчид хүндрэл учруулдаг бөгөөд үүнийг тэр бүр мэдэхгүйгээс бүртгэлийн журам зөрчих нь олонтой тохиолдож байгаа талаар мэргэжлийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид болон уригч иргэн, аж ахуйн нэгжийн зүгээс дурдсан байна.

Түр ирэгчийн бүртгэлийг яах гэж, юунаас үүдэн ажлын 7 хоногт хийж байгаа, бүртгэснээс үүдэн гарах үр ашиг нь тодорхойгүй, мөн ойлгомжгүй байна. Түүнчлэн визгүйгээр манай улсад 90 хоногоор нэвтэрдэг АНУ-ын иргэн 30 хоногоос доош хугацаагаар байх бол бүртгүүлэх шаардлагагүй, хэрвээ 30-аас дээш хонох бол орж ирснээс хойш ажлын 7 хоногийн дотор бүртгэл хийлгэхийг шаардаж, бүртгүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулж байгаа нь ойлгомжгүй байдал үүсгэдэг байна.

Түүнчлэн виз, визийн зөвшөөрлийг ялгаж чадахгүй байгаа гадаадын иргэн, уригч нь ажлын 7 хоногийн дотор бүртгүүлэх, календарийн 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрлийг мэдүүлэх үүргийг тус тус хүлээсэн нь улам ойлгомжгүй байдал үүсгэдэг ба энэ нь гадаадын иргэний урчигчийн хувьд торгуульд оруулахаар хийгдсэн “урхи” мэт харагддаг талаар зөрчлийн арга хэмжээ авагдсан уригч иргэн, аж ахуйн нэгжээс илэрхийлсэн байна.

Бусад улсын жишгийг судалж үзвэл техник, технологийн хөгжлийг ашиглан гадааын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед бүртгэл хийдэг ба удаан хугацаагаар оршин суухгүй түр ирэгчийн хувьд дахин бүртгүүлэх шаардлага байдаггүй байна. Түр ирэгчийг 7 хоногийн дотор дахин бүртгэж байгаа уг тогтолцоо нь хуучин посткоминиуст улсуудад байдаг жишиг байна. Манай улс нь бусад ардчилсан улсуудын жишгийг даган гадаадын иргэний бүртгэлийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын тоон мэдээллээр жилд ойролцоогоор 24000 орчим гадаадын иргэн түр ирэгчийн статустайгаар бүртгүүлдэг байна.

Монгол Улсад түр ирэгчээр бүртгүүлсэн гадаадын иргэд




Гадаадын иргэнийг Монгол Улсад урьж ирүүлэх урилга олголтын байдлыг судлан үзвэл доорх тоон статистик гаргасан байна.




Дээрхээс харахад гадаадын иргэнийг хувийн урилгаар Монгол Улсад урьж ирүүлэх сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжийн тоо жил ирэх тутам буурсаар байна.

Зөрчил гаргасан уригч иргэн, аж ахуйн нэгжид хүлээгэсэн торгуулийн хэмжээний талаарх тоон мэдээллийг авч үзвэл:

| Арга хэмжээ авагдсан | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | **2017** | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Аж ахуйн нэгж | 652 сая 500 мян | 315 сая 700 мян | 370 сая 754 мян | 1 тэрбум 21 сая 3 мян | 1 тэрбум 275 сая 35 мян | 1 тэрбум 483 сая 49 мян | 1 тэрбум 710 сая 489 мян | 1 тэрбум 405 сая 632 мян | 640 сая 704 мян | 534 сая 664 мянга | 871 сая 790 мянга |
| Уригч иргэн | 0 | 500 мян | 0 | 1 сая 792 мян | 999 мян | 138 сая 37 мян | 36 сая 856 мян | 11 сая 136 мян | 7 сая 872 сая | 19 сая 770 мянга | 15 сая 100 мянга |

Дээрхээс харахад зөрчил гаргаж байгаа уригч иргэн, аж ахуйн нэгжийн тоо жил ирэх тутам буурч байгаа нь харагдаж байгаа боловч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар уригчид хүлээлгэх үүргийг 30 хоногоос дээш хугацаагаар урьсан уригч иргэн, аж ахуйн нэгж гэж хугацааны хувьд хязгаарлалт буюу ялгамжтай байдал тогтоосон нь нэг талаас хийдэл, тэгш бус байдлыг үүсгэж байгаа бөгөөд нөгөө талаас гадаадын иргэнийг бүртгүүлэх үүрэг хүлээлгэсэн нь хүнд суртал, чирэгдэл үүсгэсэн шинжтэй байна. Иймд гадаадын иргэнийг урсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ямар хугацаагаар урьснаас үл хамааран адил үүрэг хүлээлгэх, гадаадын иргэдийн бүртгэлийг боловсронгуй болгох эрх зүйн үндэслэлийг хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна.

### 3.3. МОНГОЛ УЛСЫН ВИЗИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ:

Хүснэгт 7

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлээс 20 дугаар зүйл. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Монгол Улсын визийн талаарх зохицуулалт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болон гадаадын иргэдэд ойлгомжтой бөгөөд Монгол Улсын виз авахад хүндрэлгүй эсэх?<br><br>Монгол Улсын визийн талаарх зохицуулалт нь олон улсын жишигт болон аялал жуулчлалыг хөгжүүлэх Монгол Улсын бодлогыг дэмжиж чадаж байгаа эсэх? |

**ҮНЭЛГЭЭ**:Гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрэх эрх олгосон зөвшөөрлийн хуудсыг виз гэж ойлгож байгаа болно. Монгол Улсын виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй, орох, гарах-орох, дамжин өнгөрөх зориулалттай, Монгол

Улсын хилээр нэвтрэх зорилгыг агуулсан ангилалтай, нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байхаар хуульд заасан болно.

Эндээс харахад визийн талаарх дараахь ойлголтууд байна. Үүнд:

- визийн зэрэг
- визийн зориулалт
- визийн ангилал
- визийн төрөл

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу дипломат зэргийн визийг дипломат паспорттай гадаадын иргэн, улаан өнгийн лесе пасе бүхий НҮБ-ын ажилтан, албан тушаалтанд олгох ба уг визийг визийн хуудсан дээр “D” гэсэн латин үсгээр ялгаж тэмдэглэхээр заасан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасаар албан зэргийн визийг албан паспорттай бөгөөд албан хэргээр зорчих, оршин суух гадаадын иргэн, цэнхэр өнгийн лесе пасе бүхий НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын ажилтан, албан тушаалтан, олон улсын байгууллагын ажлаар ирэх энгийн паспорттай гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн, тус улсын төр, захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллага, Улсын Их Хуралд суудал бүхий намын урилгаар ирэх албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу тус улсад ажиллах албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын албан болон энгийн паспорттай ажилтанд олгох бөгөөд уг визийг визийн хуудсан дээр “А” гэсэн латин үсгээр ялгаж тэмдэглэхээр тус тус заасан байна.

Дээрхээс бусад иргэдэд олгох визийг “энгийн зэрэг”-ийн виз гэж нэрлэсэн байна. Гэтэл Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлээр Монгол Улсын визний ангилалыг тогтоож өгсөн бөгөөд уг ангилалд дипломат зэргийн виз нь D ангилал байхаар, албан зэргийн виз нь А ангилал байхаар заасан байна.

Эндээс харахад визийн зэрэг тогтоосон нь тодорхой ач холбогдолгүй бөгөөд “визийн ангилал” гэсэн ойлголтой давхардаж байна. Дэлхийн бусад улсуудын визийн талаарх зохицуулалт нь виз нь тодорхой зорилгыг харуулсан ангилалтай байх ба визийн зэрэг гэдэг ойлголт ихэнх улсад байхгүй байна. Манай хөрш БНХАУ-ын Гарах, орох хөдөлгөөнд хяналт тавих тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 1 дэх хэсгийн 16 дахь хэсэгт БНХАУ-ын виз нь дипломат, хүндэтгэлийн, албан, энгийн гэсэн төрөлтэй[3] байхаар заасан байна.

[3] БНХАУ-ын гарах, орох хөдөлгөөнийг зохицуулах тухай хуулиас

Иймээс визийн зэрэг нь тодорхой эрх зүйн үр дагаваргүй бөгөөд визийн ангилалтай давхардаж байх тул хуулийн уг зохицуулалтыг засах нь зүйтэй байна.

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдын тухай хуулиар виз нь 11 төрлийн ангилалтай байхаар хатуу тогтоож өгсөн болно. Олон улсын харилцаа хамтын ажиллагаа улам бүр хөгжиж байгаа өнөөдрийн цаг үед шинэ визний ангиллыг бий болгох, улмаар гадаадын иргэдэд учирч байгаа виз мэдүүлэхтэй холбоотой бэрхшээлийг бууруулах замаар Монгол Улсад ирэх гадаадын иргэдийн тоог нэмэгдүүлэх, тэдэнд хяналт тавих бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага манай улсад байгаа болно.

Энэ талаар Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-ийн 4.4.4-т "Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно." гэж, 5.3.12-т "Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна." гэж тус тус заасан байна.

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, дэлхийн нийт бүтээгдэхүүний 10 хувь, экспортын 7 хувь /1,6 их наяд ам.доллар/, үйлчилгээний экспортын 30 хувийг тус тус бүрдүүлж, ажил эрхэлж буй 10 хүн тутмын 1 нь тус салбарт ажлын байраар хангагдаж, шинээр бий болж буй 5 ажлын байр тутмын нэг нь тус салбарт бий болжээ. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан статистик мэдээллээс үзэхэд 2017 онд олон улсад 1,3 тэрбум жуулчин аялж /+7/, тэдгээрээс 1,3 их наяд ам.долларыг зарцуулсан /+4/ бөгөөд 2030 он гэхэд олон улсын аялагчдын тоо 1,8 тэрбумд хүрэх төлөвтэй байна. Монгол Улсын хувьд 2018 онд 529 мянган гадаад жуулчин хүлээн авч, дотоодын эдийн засагт 569 сая ам.доллар буюу 1,5 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн гэж Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан мэдээлэлд дурдсан байна.

Түүнчлэн Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг "Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт"-д дэлхийн 140 орноос Монгол Улс нийлбэр дүнгээр 93 дугаарт, "олон улсад нээлттэй байдал" буюу "**жуулчны виз олгох нөхцөл"-ийн** үзүүлэлтээр **128**, "газрын боомтын дэд бүтцийн хөгжил" үзүүлэлтээр 126, "жуулчны үйлчилгээний дэд бүтэц" үзүүлэлтээр 105, "агаарын тээврийн дэд бүтэц" үзүүлэлтээр 97 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн байна.

Энэ нь бодлогын баримт бичигт гадаадын иргэдэд үзүүлэх визийн үйлчилгээний талаар баримтлах чиглэлийг нээлттэй, хөнгөвчлөхөөр тодорхойлсон боловч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд визийг цахимаар олгох болон жуулчдыг дэмжих

зорилгоор визийг хөнгөвчлөх талаарх зохицуулалт байхгүй буюу Монгол Улсын визийн авахад маш хүндрэлтэй болох нь харагдаж байна.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын виз олголтын талаарх тоон мэдээллийг авч үзвэл:




Дээрх тоон мэдээллээс харахад 2008 оны үед 53000 гаруй визийг олгож байсан бол түүнээс хойш тогтмол буурч, 2018 онд 27000 орчим визийг олгосон байна. Иймд цаашид гадаадын иргэдэд виз олгох ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор цахим хэлбэрээр виз мэдүүлэх, олгох, холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд хилийн боомт дээр виз олгох талаарх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна.

Монгол Улсын иргэнээс гадаад улсад төрж гадаад улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхэд болон монгол угсаатай иргэдэд виз олгох асуудалд хөнгөлттэй хандах бодлого үгүйлэгдэж байгаа боловч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор батлагддаг Монгол Улсын визийн журам зэрэгт энэ талаарх зохицуулалт байхгүй байна.

Иймд Монгол Улсын визтэй холбоотой зохицуулалтыг илүү уян хатан болгох, цаг үеийн хөгжлөө дагаж тогтмол шинэлэгдэн сайжирдаг байх шаардлага тулгарч байна. Мөн олон улс орон хэрэгжүүлж байгаа визийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилго бүхий виз мэдүүлгийн төвийн тухай зохицуулалт манай хууль тогтоомжид байхгүй байна. Иймд энэ талаарх зохицуулалтыг хуульд тусгах нь Монгол Улсын визийн мэдүүлгийг Виз мэдүүлгийн төвөөр хүлээн авах боломжийг бүрдүүлэх бөгөөд гадаад улс оронд Монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын иргэдэд хүргэх үйлчилгээг ойртуулах, хууль бус дундын зуучлалыг багасгах, дипломат төлөөлөгчийн газруудын ачааллыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой байна. Иймд энэ талаарх зохицуулалтыг мөн хуульд тусгах шаардлагатай байна.

Мөн олон улсын гэрээ, хэлцэлд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх боломж, боломцоог гишүүн

орнуудаа олгох зорилгоор Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенцийг НҮБ 2005 онд баталсан. Энэхүү конвенцид Монгол Улс нэгдэхээр[4] бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа талаар албн эх сурвалж мэдээлсэн болно. Энэ нь цаашид бид олон улсын чиг хандлагад нийцүүлэн хууль тогтоомжоо боловсронгуй болгох шаардлагатай болохыг харуулж байна.

Манай улс Иргэний агаарын тээврийн Чикагогийн конвенцын 9 дүгээр хавсралтын 3.23-т заасан зөвлөмжийн хэрэгжүүлэн “гарах-орох” виз гэсэн визний зориулалтыг байхгүй болгож хуулиас хасах шаардлагатай байна. БНСУ, БНХАУ, Шенгений орнууд болон ихэнх улсууд нь оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэнээс “гарах-орох” виз авахыг шаарддаггүй бөгөөд ОХУ нь нэг жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж буй гадаадын иргэдэд олон удаагийн виз олгож, удаан хугацаагаар оршин суугчаас олон удаагийн гарах-орох виз авахыг шаарддаггүй байна.

Нөгөө талаас “гарах-орох” визийг байхгүй болгосноор уригч байгууллага, иргэнтэйгээ хөрөнгө мөнгөний маргаантай гадаадын иргэн дураараа гараад явах магадлалтай гэж үздэг этгээдүүд байх боловч олон удаагийн визтэй гадаадын иргэн хэдийд ч гараад явах боломжтой бөгөөд уригч нь энэ эрсдэлийг даана хэмээн урьж авчирсан тул ганц нэг тохиолдолд тааруулж, хуулийг тэр чигт хүндрүүлж, оршин суух зөвшөөрөлтэй иргэдэд дахин “гарах-орох” виз олгох нь хүнд суртал бий болгож байх тул энэ зориулалтын визийг хуулиас хасах шаардлагатай юм.

Түүнчлэн Монгол Улсын визийн хүчинтэй хугацаа нь олгосон өдрөөс хойш “90 хоног” байхаар заасан нь дэлхийн бусад улстай харьцуулахад маш богино бөгөөд Иргэний агаарын тээврийн Чикагогийн конвенцын 9 дүгээр хавсралтын 3.26-д визийн хүчинтэй хугацааг уртасгах талаар гишүүн оронд зөвлөмжилсөн байдагт нийцүүлэн Монгол Улсын визийн хугацааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “90 хоногийн” гэснийг хамгийн багадаа “180 хоног” болгож уртасгах нь зүйтэй байна.

Дэлхийн аялал жуулчлалын салбарт цахим технологиор тэргүүлэгч Амадиус компаний гаргасан статистик мэдээллээс үзэхэд дэлхий дахинд 2018 онд Монгол Улсад аялахыг хүссэн 114 сая иргэд /давтагдсан тоогоор/ цахим хайлт хийсэн бөгөөд үүнээс 20 сая Солонгос, 19 сая Америк, 13 сая нь БНХАУ-ын иргэд байсан бөгөөд 2019 онд Монголд аялахаар хайлт хийсэн хүний тоо 85 хувиар өссөн байна. Энэ Монгол Улс аялал жуулчлалын талаар таатай бодлого хэрэгжүүлвэл манай улсыг зорин ирэх сонирхол бүхий жуулчид бидний зорьж байгаагаас ч илүү байгааг харуулж байна.

Нөгөө талаас Монгол Улс зуны улиралд нэг өдөрт 72 гаруй мянган жуулчин хүлээж авах ор/хоногийн хүчин чадалтай бөгөөд үүнээс үзэхэд 5-9 дугаар сарууудад 1,2

[4] Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 3 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, Ийр://сКа.доу.тп/щр-соп1еп!/ир1оас15/2018/10/3-1абМ.рс1? суулд үзсэн 2018.12.17.

сая жуулчин хүлээж авах бүрэн хүчин чадалтай гэж салбарын яам нь тооцоо гаргасан байна.

Монгол Улс дэлхийн жуулчлалын урсгалын 25 хувь буюу 320 гаруй сая жуулчдыг татдаг Ази, Номхон далайн бүс нутагт оршдог хэдий ч жилд 500 гаруйхан мянган гадаадын жуулчин хүлээн авч байгаа нь чамлахаар үзүүлэлт юм.

Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж буй орнуудын туршлага, тэр дундаа Зүүн өмнөд Азийн орнуудын туршлагыг харахад **жуулчны визийг чөлөөлөх**, хилийн боомт дээрээс виз олгох нөхцөлийг бүрдүүлэх, цахим визийг нэвтрүүлэх зэргээр гадаадын жуулчдын тоогоо огцом нэмэгдүүлэх бодлого барьсан байна.

Тухайлбал ОХУ-ын Приморийн хязгаарын Владивосток хот Солонгос, Хятадын жуулчдыг 72 цаг визгүй зорчуулж эхэлснээр жилд ирэх жуулчдын тоогоо 114 хувиар өсгөсөн байна. Мөн БНХАУ-д энгийн пасспортаар 30 гаруй улс визгүй зорчиж, жуулчны компаниар ирж тохиолдолд 5 улсын иргэдийг визээс чөлөөлдөг байна. мөн тус улсын аялал жуулчлалын гол бүс нутаг болох Хайнан мужид аяллын компаниар ирж буй 59 улсын иргэд визгүй зорчиж байна.

Түүнчлэн Япон улсад 68 улсын иргэд, БНСУ-д 112 улсын иргэд, тэр дундаа тус улсын аялал жуулчлалын чөлөөт бүс Жэжү арал руу 30 хоногийн хугацаанд тусгай жагсаалтад багтсан 24 улсаас бусад улсын иргэд визгүй аялдаг бол Тайланд улс руу энгийн пасспорт бүхий 69 улсын иргэд визгүй, 18 улсын иргэд хилийн боомт дээрээс виз авах боломжтой байна.

Ази, Номхон далайн бүсийн Вьетнам, Камбож, Киргизстан, Казакстан, Узбекстан зэрэг улс орнууд цахим системээр дамжуулан электрон визийг ажлын 4 цагаас 3 хоногт багтаан олгодог байна. Эдгээр нь 100 хувь онлайн үйлчилгээ бөгөөд визээ улсын хил дээр шууд олгодог байна.

Иймд дээрх улс орнуудын жишгээр Монголд ирэх гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “жуулчны виз”-ны асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Мөн үнэлгээнд дурдсан бусад асуудлаар визийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Хавсралт хэсэгт зарим улсуудын визгүй зорчих улсуудын талаарх мэдээллийг үзнэ үү.

## 3.4.ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 22 ДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСАД ОРОХЫГ ҮЛ ЗӨВШӨӨРӨХ

Хүснэгт 9

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 22.1.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө:<br>22.1.1. 16 насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй гадаадын иргэн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол;<br>22.1.2.Монгол Улсад ял шийтгүүлсний дараа тус улсаас гарсан бөгөөд ялгүйд тооцох хугацаа нь дуусаагүй бол;<br>22.1.3.Монгол Улс тааламжгүй этгээд гэж зарласан бол;<br>22.1.4.олон улсын хэмжээнд эрэн сурвалжилж байгаа бол;<br>22.1.5.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахад харшилж байвал;<br>22.1.6.Монгол Улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй бол;<br>22.1.7.энэ хуульд заасан журмын дагуу албадан гаргасан бөгөөд Монгол Улсад орохыг хориглосон хугацаа дуусаагүй бол. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх зохицуулалт нь практикт бүрэн нийцэж буй эсэх?<br><br>Уг зохицуулалтын нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? |

**ҮНЭЛГЭЭ:** Тусгаар тогтносон, бүрэн эрхт улс болохын хувьд улсын хилээр оруулах болон оруулахгүй байх иргэдийн талаарх зохицуулалтыг хууль тогтоомждоо тусгаж өгдөг нь олон улсын жишиг юм.

Орохыг үл зөвшөөрөх гэдэг нь гадаадын иргэн өөрөө арилгаж болох хүчин зүйл, шалтгаанаас үүдэн тухайн улсын хилээр орж чадалгүй буцаагдахыг хэлдэг бөгөөд эдгээр шалтгаанд ихэвчлэн паспорт, виз, төлбөрийн чадвар, өвчин, ирсэн зорилгодоо нийцэхгүй, тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй байдал зэргийг ойлгодог байна. Орохыг үл зөвшөөрөх болсон шалтгааныг арилгасан тохиолдолд тухайн улсруу орох эрхтэй бөгөөд орохыг үл зөвшөөрөх шийдвэрийг шилжилт хөдөлгөөний ажилтан гадаадын иргэнийг хил дээр ирэхэд нь гаргадаг байна. Дэлхийн бусад улс орнуудын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах хууль тогтоомжид энэ талаар ихэвчлэн зааж өгсөн байдаг байна.

Тухайлбал БНХАУ-ын Гарах-орох хөдөлгөөнд хяналт тавих тухай хуулийн 25 дугаар зүйлээр тус улсад дараахь нөхцөлд орохыг үл зөвшөөрөхөөр заасан байна: Үүнд

- Хүчин төгөлдөр бичиг баримтгүй, эсхүл бичиг баримтаа шалгуулахаас татгалзсан, зайлсхийсэн;
- Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 1-4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал буюу виз олгохоос татгалзсан шийдвэр гарсан, албадан гаргагдсан болон эх оронд нь буцаасны улмаас БНХАУ-д орохыг хориглосон хугацаа дуусаагүй; Сэтгэл зүйн хүнд эмгэгтэй, халдварт сүрьеэ болон бусад халдварт өвчний улмаас олон нийтийн эрүүл мэндэд аюул учруулахаар, БНХАУ-ын үндэсний аюулгүй байдал болон ашиг сонирхолд аюул учруулах, нийгмийн болон олон нийтийн дэг журмыг тасалдуулах, хууль бус үйл ажиллагаа эрхлэх болон гэмт хэрэг үйлдэхээр, визийн мэдүүлгийг хуурамчаар мэдүүлсэн, БНХАУ-д оршин суух зардлаа өөрөө гаргаж чадахгүй бол;
- БНХАУ-д нэвтэрсний дараа ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулахаар бол;
- Хууль тогтоомжид заасан бусад БНХАУ-д нэвтрүүлэхээс татгалзах нөхцөл байдал үүссэн" гэж маш тодорхой зохицуулсан байна.

"Орохыг үл зөвшөөрөх"-өөс гадна "орохыг хориглох" тухай ойлголт байдаг бөгөөд орохыг хориглох нь "албадан гаргагдсан, эсхүл улс орны үндэсний аюулгүй байдлын үүднээс тус улсад тодорхой хугацаагаар гадаадын иргэнийг оруулахгүй байх" тухай ойлголт ба Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь "Захиргаанаас эсхүл шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох болон оршин байхыг хориглохыг хэлнэ" гэж тодорхойлжээ. (Glossary on Migration, IOM, 2011). Орохыг хориглох шийдвэрийг гадаадын иргэнийг тус улсад байхад нь буюу албадан гаргагдахад нь, эсхүл зарим нэг улс гадаад байхад нь гаргадаг туршлага байна.

Монгол Улсын хувьд Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлээр орохыг үл зөвшөөрөх үндэслэлийг зааж өгсөн боловч орохыг хориглох үндэслэлтэй хольж хуульчилсан боловч энэ нь ноцтой зөрчил үүсгээгүй байна. Харин манай улсын тухайд дэлхийн ихэнх улс хуулиараа тогтоож өгсөн "**сэтгэл зүйн хүнд эмгэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтох өвчин, халдварт сүрьеэ болон бусад нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй өвчнөөр өвчилсөн этгээд болон Монгол Улсад ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй, ирсэн зорилгодоо нийцээгүй визийн ангилалтай иргэд"-ийг** орохыг үл зөвшөөрсөн зохицуулалт байхгүй байна.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статистикт орохыг хориглох шийдвэр гаргасан талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Иймд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд зарим ноцтой өвчтэй болох нь илэрхий иргэдийг хилээр орохыг үл зөвшөөрөх талаарх зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

## 3.5.ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 24 ДҮГЭЭР ЗҮЙЛ.ГАДААДЫН ИРГЭНИЙГ БҮРТГЭХ

Хүснэгт 12

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 24 **дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх**<br>24.1.Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.<br>24.2.Гадаадын иргэнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг бүртгүүлэх үүргийг хүлээнэ.<br>24.3.Энэ хуулийн 24.2-т зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.<br>24.4.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.<br>24.5.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаад улсын иргэнийг бүртгэхдээ татвар төлөгчийн дугаарыг олгоно. Татвар төлөгчийн дугаарын тоон агуулга, хэлбэрийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Гадаадын иргэний бүртгэл нь практикт нийцэж буй эсэх?<br>Олон улсын чиг хандлагын дагуу гадаадын иргэдийн бүртгэлийг хийхэд хуулийн зохицуулалт нь хангалттай эсэх? |

### ҮНЭЛГЭЭ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон төрийн байгууллагын урилгаар ирсэн, Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээдэг.

Хуулийн дээрх зохицуулалтаас харахад 30-аас доош хоногоор ирсэн иргэдийг тусгайлан бүртгэл хийлгэхийг шаарддаггүй байна. Мөн гадаадын иргэнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг бүртгүүлэх үүргийг давхар хүлээлгэсэн бөгөөд энэ талаар үнэлгээний тайлангийн 3.2 дахь хэсэгт тодорхой дурдсан болно. Уригчгүй тохиолдолд гадаадын иргэн өөрөө гадаадын иргэний асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй [5] байна.

Засгийн газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 9.2.3 дахь заалтад зааснаар гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх, албадан гаргах болон дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журмыг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд хуулийн уг заалтыг үндэслэн Засгийн газрын 2018 оны 146 дугаар тогтоолоор гадаадын иргэнийг бүртгэх харилцааг зохицуулж байна.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 2018 оны жилийн эцсийн тайланд[6] мэдээлснээр "Монгол Улсад оршин суух үнэмлэх" 9,654 ширхэгийг шинээр хэвлэн, 9889 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 197 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийж, цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 129 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 663 иргэний хувийн хэрэгг баяжилт хийн нийт 1083 иргэний мэдээллийг цахим архивд оруулсан байна. Мөн гадаадын 55 иргэнд регистрийн дугаар олгож, харьяалалгүй 1 иргэнд зорчих үнэмлэх олгосон байна.

Монгол Улс нь оршин суух зөвшөөрөл авахгүй 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгчийн бүртгэлийг ажлын 7 хоногийн дотор хийлгэх шаардлага тавьдаг бөгөөд энэ нь эрх зүйн ямар ач холбогдолтой нь тодорхойгүй байна. Уг нь тухайн иргэний улсын хилээр нэвтрэх үед Хил хамгаалах байгууллагаас Монгол Улсад орж ирсэн талаар бүртгэл хийж байгаа боловч дахин 7 хоногийн хугацаанд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх шаардлагатай байгаа нь гадаадын иргэдэд нэг төрлийн хүндрэл үүсгэдэг байна.

Уг бүртгэлийг хийлгэхгүй байх нь Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.1-д заасан бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчих зөрчилд тооцогддог бөгөөд гадаадын иргэнийг нэг зуун нэгж, уригч иргэн, аж ахуйн нэгжийг 250-2500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах үр дагавартай юм. Цаашлаад энэ нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтад заасан "түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;" бол Монгол Улсаас албадан гаргах үндэслэлд тооцогдох ноцтой үр дагавартай юм.

Энэхүү зохицуулалт нь гадаадын иргэдэд маш их хүндрэл учруулдаг бөгөөд цаашид үүнийг хөнгөвчлөх, төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох,

[5] Засгийн газрын 2018 оны 148 дугаар тогтоол "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам"

[6] Гадаадын иргэн, харьяатын газраас 2018 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан

бүртгэлийг хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг ашиглан хийх зэргээр өөрчлөх шаардлагатай юм.

Манай хуульд заасан түр ирэгч болон бусад гадаадын иргэдийн бүртгэлийг яах гэж, юунаас үүдэн ажлын 7 хоногт хийж байгаа, бүртгэснээс бий болох ач холбогдол нь тодорхойгүй, ойлгомжгүй байна. Жишээ нь: визгүйгээр манай улсад 90 хоногоор нэвтэрдэг АНУ-ын иргэн 30 хоногоос доош хугацаагаар байх бол бүртгүүлэх шаардлагагүй, хэрвээ 30-аас дээш хонох бол орж ирснээс хойш ажлын 7 хоногийн дотор бүртгэл хийлгэхийг шаардаж, бүртгүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулж байгаа нь ойлгомжгүй байдал үүсгэж байна.

Гадаадын иргэдийн гаргаж байгаа зөрчлийг зөрчлийн төрлөөр гь авч үзвэл:

| Д/Д | Зөрчлийн төрөл | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Оршин суух журам зөрчсөн | 600 | 244 | 327 | 134 | 123 | 83 | 79 | 104 | 70 | 85 |
| 2 | Визийн хугацаа хэтэрсэн | 1779 | 1397 | 1237 | 2408 | 2008 | 1699 | 1007 | 910 | 815 | 668 |
| 3 | Бүртгэлийн журам зөрчсөн | 645 | 478 | 275 | 321 | 431 | 791 | 360 | 362 | 332 | 366 |
| 4 | Хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн | 864 | 530 | 137 | 461 | 313 | 235 | 76 | 49 | 75 | 257 |
| 5 | Дамжин өнгөрөх журам зөрчсөн | 16 | 33 | 34 | 83 | 18 | 7 | 14 | 31 | 14 | |
| 6 | Байнга оршин суух үнэмлэх үрэгдүүлсэн | - | - | 15 | 30 | 82 | 413 | 330 | 14 | 187 | 247 |
| 7 | Бичиг баримтаа биедээ авч яваагүй, хаягийн бүртгэл хийгээгүй | - | 8 | 70 | 469 | 695 | 641 | 128 | 102 | 322 | 239 |
| 8 | Зөвшөөрөл олгох журам зөрчсөн | 18 | 7 | 7 | - | 7 | 0 | 0 | 0 | 1 | - |
| 9 | Бусад зөрчил | - | - | 171 | 9 | 3 | 2 | 5 | 1 | - | 20 |

Зөрчлийн тухай хуульд гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжтой холбоотой үндсэн 8, бусад 1 нийт 9 төрлийн зөрчлийг тогтоож өгсөн байна.

Гадаадын иргэдийн гаргаж байгаа зөрчилд бүртгэлийн журам зөрчих зөрчил ямар хувь хэмжээг эзэлж байгааг 2001 оноос хойш буюу Гадаадын иргэн, харьяатын газар байгуулагдсан үеэс нэгтгэн авч үзвэл дараахь графикаас харах боломжтой байна.




Гадаадын иргэдийн хамгийн түгээмэл гаргадаг зөрчил нь визийн хугацааг хэтрүүлэх зөрчил бол түүний дараагаар “бүртгэлийн журам зөрчих” зөрчлийг маш их гаргадаг байна. Энэ нь ихэвчлэн тухайн гадаадын иргэн 7 хоногийн дотор бүртгүүлэх ёстой гэсэн хууль тогтоомжийг мэдэхгүйгээс үүдэн гаргадаг зөрчил бөгөөд виз, визийн зөвшөөрлийг ялгаж чадахгүй байгаа гадаадын иргэн, уригч нь ажлын 7 хоногийн дотор бүртгүүлэх, календарийн 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрлийг мэдүүлэх зэргээр хугацаа тогтоосон нь улам бүр ойлгомжгүй байдал үүсгэн, энэ нь торгуульд оруулахаар хийгдсэн “урхи” шиг харагддаг талаар дурдсан байна.

Иймд холбогдох бодлогын баримт бичигт гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөвчлөх, жуулчдыг татах талаар бодлого баримтлахаа илэрхийлсэн тул гадаадын иргэдийн бүртгэлийн талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын чиг хандлагад нийцүүлэн техник, технологийн хөгжлийг энэ салбарт ашиглах боломжийг бүрдүүлэхээр эрх зүйн орчин өөрчлөх шаардлагатай байна.

## 3.6. ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 34 ДҮГЭЭР ЗҮЙЛ.МОНГОЛ УЛСААС ГАРАХ, ГАРАХЫГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

Хүснэгт 12

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 34.2.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:<br>34.2.1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл;<br>34.2.2.шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;<br>34.2.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол.<br>34.3.Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана.<br>34.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Гадаадын иргэдийг гарахыг түдгэлзүүлэх үндэслэл нь практикт бүрэн нийцэж буй эсэх? |

**Үнэлгээ:** Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3-т заасан журмын дагуу “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-ыг баримтлан гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргадаг байна.

Шийдвэрийг гаргахдаа журмын 2.1-д заасны дагуу шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон прокурорын байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэл болгодог байна.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан статистикаас гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гаргасан байдлыг графикаар үзүүлвэл:




Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол” гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэхээр зохицуулсан.

Гэтэл Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1.4-т “эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр хязгаарлах арга хэмжээ авах”-аар, 5.5 дугаар зүйлд Зөрчлийн тухай хуулиар арван мянган нэгжээс дээш нэгжтэй тэнцэх зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх шийдвэрийг эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн Прокурор гаргахаар тус тус заасан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 59 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхийг хориглоно” гэж заасан нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1-д заасантай зөрчилдөж байна.

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжиид татварын өр төлбөртэй, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотойгоор гадаадын иргэний гарахыг түдгэлзүүлэх асуудал тусгагдаагүй байна. Үүнээс үүдэн улсын хилээр өр төлбөртэй этгээд гарч явсан тохиолдолд иргэнээсээ аваад улс хүртэл хохирч үлдэх магадлалтай юм. Иймд гарахыг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

## 3.7. ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 37 ДУГААР ЗҮЙЛ.ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАХ

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 37.1.Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараахь үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:<br><br>37.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;<br><br>37.1.2.оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;<br><br>37.1.3.түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;<br><br>37.1.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;<br><br>37.1.5.Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон;<br><br>37.1.6.хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;<br><br>37.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;<br><br>37.1.8.энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;<br><br>37.1.9.нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;<br><br>37.1.10.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;<br><br>37.1.11.шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;<br><br>37.1.12.түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Гадаадын иргэдийг албадан гаргах зохицуулалтыг прхактикт хэрэглэхэд хүндрэл тулгарч байгаа эсэх? |

ҮНЭЛГЭЭ: Албадан гаргах гэдэг нь тусгаар тогтносон, бүрэн эрхт улс нь өөрийн нутаг дэвсгэр дээр оршин суугаа гадаадын иргэнийг холбогдох зөрчил гаргасных нь төлөө тухайн этгээдийн хүсэл, сонирхлыг үл харгалзан нутаг дэвсгэрээсээ албадан

буцаах ажиллагаа юм. Албадан гаргах үндэслэлийг улс орон бүр дотоодын хууль тогтоомждоо тусгаж өгсөн байх ба ихэвчлэн эдгээр нь нилээд ноцтой шалтгааныг дурдсан байдаг байна. Монгол Улсын хувьд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд албадан гаргах үндэслэлийг зааж өгсөн бөгөөд нийтлэг жишигтэй адил боловч 37 дугаар зүйлийн 37.1.3-т “түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;” “37.1.9.нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;” гэсэн үндэслэлийг оруулж өгсөн байна.

Зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулах хариуцлага нь бүртгэлийн журам хоёр удаа зөрчсөн үндэслэлээр албадан гаргахад хүргэх юм. Өөрөөр хэлбэл, түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн, нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн тохиолдолд тухайн гадаадын иргэнийг албадан гаргах шаардлагатай болдог.

Гэтэл виз, бүртгэлийн асуудалд манай улсаас шалтгаалсан зөрчил дутагдал нэлээд байгаа бөгөөд бүртгэлийн асуудал нь гадаадын иргэнийг зөрчилд оруулах түгээмэл шалгаан болдог талаар өмнөх хэсэгт дурдсан болно. Тухайлбал, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлд “бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн” *(ЗГ-ын 2018 оны 146 дугаар тогтоол буюу бүртгэлийн журмын 2.2-т гадаадын* ***иргэн өөрөө бүртгүүлэх тухай заасан ч хэрхэн, яаж мэдээлэл авч бүртгүүлэх нь тодорхойгүй),*** “Гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасан хугацаанд зохих байгууллагад бүртгүүлээгүй бол...”, “визийн байх хугацааг хэтрүүлсэн бол гадаадын иргэн тус бүрээр зөрчилд тооцон хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” (***өргөн уудам газар нутагтай хэдий ч зам, харилцаа холбоо хангалттай хөгжөөгүйгээс хугацаа хэтрэх тохиолдол гардаг)*** гэх мэтээр заасан нь зөрчлийг тодорхойлсон нэгдсэн ойлголттой болсон хэдий ч эдгээр зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо бүрдээгүй байна.

Энэ талаар Үндэсний аудитын газраас хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитаар “хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна”[7] гэснээс харж болох юм.

---

[7] Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан

Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулахаар УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.4-т тусгагдсан хэдий ч энэхүү зорилтыг хангахад манай улсын виз, бүртгэлийн асуудал хоцрогдсон, хууль тогтоомж, дүрэм, журам өөр хоорондоо нийцэхгүй давхардсан, зөрчилдсөн, хийдсэн төдийгүй, цаг үеэсээ хоцрогдсон уялдаа холбоо хангалтгүй байгаа нь сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, гадаадын аялагч, жуулчид болон зорчигчдод сэтгэл зүйн хувьд дарамт, хүндрэл учруулах, дахин манай орныг зорих хүсэл эрмэлзэл буурах шалтгаан болдог тухай холбогдох хүмүүс дурдсан байна.

Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн[8] 9 дүгээр хавсралтын III бүлгийн 5.18.1 -д тохиролцогч улсууд болон агаарын тээвэрлэгчид нь боломжтой бол албадан гаргаж буй хүний талаар 24 цагийн турш холбогдож бүх сувгийг ажиллуулахыг зөвлөмж болгодог. Мөн тус конвенцийн 5.21-д заасны дагуу тохиролцогч талууд "нислэг эхлэх улсын, эсхүл дамжин өнгөрөх улсын төрийн эрх бүхий албан байгууллагуудад тухайн хүний талаарх холбогдох мэдээллийг өгөх, тохиролцогч талууд албадан гаргаж буй хүний бичиг баримтын хамт агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгөх"[9] үүрэг хүлээдэг. Иймд тухайн албадан гаргаж буй этгээдэд холбогдох конвенцийн 5.19 (а) албадан гаргах шийдвэрийн хуулбар, (б) харгалзагчтай бол түүний нэр, улсын харьяалал зэрэг нь зайлшгүй шаардлагатай байдаг. Олон улсын жишигт нийцүүлэх үүднээс тухайн улс нь өөртөө хувийн мэдээллийн бүрдүүлбэртэй байх нь урьдчилан сэргийлэх, ирээдүйд гарч болзошгүй аюулыг таслан зогсоох чухал ач холбогдолтой юм.

ХБНГУ, Шинэ Зеланд, Сингапур, БНХАУ зэрэг улсын жишээнээс харахад гадаадын иргэний эрх зүйн байдлыг зохицуулж буй суурь хууль тогтоомждоо зөрчил гаргасан гадаадын иргэнд сануулах, торгох, баривчлах, хууль бусаар олсон орлогыг хураах, албадан гаргах зэрэг хэд хэдэн төрлийн үндсэн арга хэмжээг авах тухай нийтлэг арга хэмжээ хэрэглэдэг байна.[10] Эдгээр арга хэмжээг зөвхөн зөрчил гаргасан гадаадын иргэнээс гадна түүнийг урьсан, батлан даасан, бүртгэсэн /жишээлбэл зочид буудал/, хувь хүн, албан байгууллага болон төрийн албан хаагчид мөн адил ногдуулдаг. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргасан гадаадын иргэн, гадаадын иргэний энэ үйлдлийг нуун дарагдуулсан, дэмжсэн, хамтарсан, мэдээлэх үүргээ биелүүлээгүй зэрэг үйлдэл гаргасан этгээдэд давхар арга хэмжээ авахаар зохицуулсан байна.

---

[8] Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенци. 1944 он.

[9] ГИХГ, Мэдээлэл 2018/1 Уб., 2018 он.

[10] Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын зарим зохицуулалт, харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2015 он. 96 дахь тал.

Өнгөрсөн хугацаанд албадан гаргагдсан гадаадын иргэдийн талаарх статистик мэдээллийг авч үзвэл:




Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд албадан гаргагдах үндэслэлийн талаар зохицуулалт тусгагдсан хэдий боловч албадан гаргагдахаас чөлөөлөгдөх нөхцөл байдлын талаар зохицуулалт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл виз, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлэх болон бүртгэлийн болон нийгмийн хэв журмыг хоёр ба түүнээс дээш удаа зөрчих зэрэг зөрчил гаргасан нөхцөл байдал буюу хүндэтгэн үзэх бусад нөхцлийн улмаас дээрх зөрчлийг гаргасан тохиолдолд албадан гаргахаас чөлөөлөх үндэслэлийн талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн гадаадын иргэн хүний наймааны зэрэг гэмт хэргийн хохирогч болсон, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас виз, оршин суух зөвшөөрлийн хугацаагаа хэтрүүлсэн зэрэг тохиолдолд үүнийг харгалзан үзэх тохиолдолын талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

## ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2010 онд баталсан бөгөөд уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох зорилгоор хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг Монгол Улсад оргонол хүсэх тухай, Монгол Улсын визийн талаарх зохицуулалт, гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг, гадаадын иргэдийн бүртгэлийн зохицуулалт, Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх, гарахыг түдгэлзүүлэх, албадан гаргах зэрэг долоон бүлэг асуудалтай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй бөгөөд дараахь чиглэлд нэмэлт, өөрчлөлтийг томьёолох нь шаардлагатайг дүгнэлт, зөвлөмж болгон товчлон хүргүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжоор Монгол Улс нь үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орогнох эрх олгох асуудал нь нээлттэй байгаа боловч уг асуудлыг хэрхэн зохицуулах, ямар нөхцөл, шаардлагыг хангасан хүнд оргонол олгох зэрэг журамласан зохицуулалт дотоодын хууль тогтоомжид байхгүй байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсад оргонол олгосон асуудал байгаагүй боловч цаашид ийм асуудал гарвал хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иймд гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад орогнох эрх олгох талаарх нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгах, эсхүл нарийвчилсан журам тогтоох эрх олгосон заалтыг хуульд нэмэлт оруулах нь зүйтэй байна.
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар гадаадын иргэнийг Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн гадаадын иргэнийг холбогдох байгууллагад бүртгүүлэх, Монгол Улсад байх хугацаанд хөрөнгийн баталгаа гаргах, Монгол Улсаас виз, оршин суух зөвшөөрлийн хугацаанд буцаах үүргийг хүлээдэг болно. Хуулийн энэ зохицуулалтанд анхаарах шаардлагатай хоёр асуудал байгаа болно. Юуны өмнө уригчийн үүргийг гадаадын иргэний Монгол Улсад оршин суух хугацаагаар ялган тогтоосон. Өөрөөр хэлбэл 30-аас доош хоногоор урьсан бол ямар нэг үүрэг хүлээгээгүй байна. Энэ нь тэгш бус байдлыг бий болгосон байна. 30-аас дээш хоногоор ирж байгаа гадаадын иргэний уригчид Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш 7 хоногийн дотор тухайн гадаад иргэнээ эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээлгэсэн нь уригч иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүндрэл үүсгэдэг бөгөөд хамгийн түгээмэл гаргадаг зөрчилд ордог байна. Иймд техник, технологийн хөгжлийг ашиглаж, бусад улс орнуудын жишгийн дагуу гадаадыйн иргэнийг улсын хилээр нэвтрэх үед холбогдох бүртгэлийг хийдэг болох шаардлагатай байна.
- Монгол Улсын виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй, орох, гарах-орох, дамжин өнгөрөх зориулалттай, Монгол Улсын хилээр нэвтрэх зорилгыг агуулсан ангилалтай, нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байхаар хуульд заасан байна.

Визийн зэрэг нь визийн ангилал гэсэн ойлголттой давхцаж байгаа бөгөөд визийн ангилал дотор D буюу дипломат, A буюу албан гэсэн ангиллын виз байдаг болно. Иймээс визийн зэрэг гэснийг хуулиас хасч, визийн ангилал гэдэгт багтаан зохицуулах нь зүйтэй бөгөөд бусад улсын жишигт нийцэж байна. Мөн хуулиар визийн ангилллыг хатуу тогтоож өгсөн нь цаашид түүнийг нарийвчлах болон илүү тодорхой болгох боломжгүй байдлыг бий болгож байх тул визний ангиллыг илүү уян хатан, нарийвчилсан, тодорхой болгох үүднээс визний ангиллыг хуулиар хатуу тогтоох бус Засгийн газрын батлах визийн журмаар нарийвчлан тогтоох шаардлагатай. Мөн олон улсын чиг хандлагыг харгалзан цахим виз олгох, виз мэдүүлгийн төвөөр дамжуулан виз мэдүүлэх боломжийг хангасан эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Визийн талаарх зохицуулалтыг уян хатан болгож, олон улсын жишигт нийцүүлэх нь монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг ойртуулах, визийн хууль бус дундын зуучлалыг багасгах, дипломат төлөөлөгчийн газруудын ачааллыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монгол Улс өөрийн улсад нэвтрэн орж ирж байгаа гадаадын иргэдийн бүртгэлийг .30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон албан хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хийдэг журамтай. Орж ирснээс хойш 7 хоногийн дотор бүртгүүлэх, 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах зэрэг олон үүргийг хуулиар бий болгосон нь гадаадын иргэд болон түүний уригчид ихээхэн хүндрэл учруулдаг болохыг хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд тодорхой болсон болно. Дэлхийн Улс орнууд тухайн гадаадын иргэнийг хилээр нэвтрэх үед бүртгэл хийдэг болсон энэ цаг үед манай гадаадын иргэний бүртгэлийн тогтолцоо хэт хоцрогдсон, дарамт үүсгэсэн байдалтай байна. Мөн гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх Монгол Улсад оршин суух хугацаанаас үл хамааран, биеийн давхцахгүй өгөгдлөөр бүртгэх тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй байна.
- Бүрэн эрхт улсын бусад улсын хилээр иргэдийг нэвтрүүлэхээс гадна орохыг үл зөвшөөрсөн тохиолдлын талаар хууль тогтоомжоороо тогтоож өгөх нь нийтлэг жишиг юм. Монгол Улс Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлээр орохыг үл зөвшөөрөх үндэслэлийг зааж өгсөн боловч онолын хувьд орохыг хориглох үндэслэлтэй хольж хуульчилсан боловч энэ нь ноцтой зөрчил үүсгээгүй байна. Харин манай улсын тухайд дэлхийн ихэнх улс хуулиараа тогтоож өгсөн “**сэтгэл зүйн хүнд эмгэгтэй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтох өвчинтэй, халдварт сүрьеэ болон бусад нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй өвчнөөр өвчилсөн этгээд болон Монгол Улсад ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй, ирсэн зорилгодоо нийцээгүй визийн ангилалтай иргэд”-ийг** орохыг үл зөвшөөрсөн зохицуулалтыг хуульдаа тусгаагүй байгааг анхаарч, энэ талаарх зохицуулалтыг хуульд нэмж оруулах нь зүйтэй байна.

- Гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд зохицуулсан боловч татварын өр төлбөртэй, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотойгоор гадаадын иргэний гарахыг түдгэлзүүлэх асуудал тусгагдаагүй орхигдсон байна. Үүнээс үүдэн улсын хилээр өр төлбөртэй этгээд гарч явсан тохиолдол гарч байсан бөгөөд ийм тохиолдолд иргэнээсээ аваад улс хүртэл хохирч үлдэх магадлалтай юм. Иймд гарахыг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулахгүй шаардлагатай.
- Монгол Улсаас албадан гаргах үндэслэл дотор түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн; нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлснийг зааж өгсөн байдаг. Гэтэл виз, бүртгэлийн асуудалд манай улсаас шалтгаалсан зөрчил дутагдал нэлээд байгаа бөгөөд бүртгэлийн асуудал нь гадаадын иргэнийг зөрчилд оруулах түгээмэл шалгаан болдог талаар тодорхой дурдсан болно. Иймд уг үндэслэлийг уян хатан авч үзэх, бүртгэлийн тогтолцоогоо сайжруулах шаардлага байна. Мөн албадан гаргагдахаас чөлөөлөгдөх нөхцөл байдлын талаар хуульд зохицуулалт тусгагдаагүй байгааг анхаарч судлах нь зүйтэй байна.

-----oOo-----

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


НЭГ. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он.
2. Олон улсын иргэний нисэхийн тухай тухай Чикагогийн Конвенци. 1944 он.
3. Улс болон гадаад улсын иргэний хооронд херенге оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенци 1965 он.

ХОЁР. ХУУЛЬ

1. Монгол Улсын Үндсэн хууль, ТМЭ, 1992 он, №1
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, ТМЭ 1993 он, №13
3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, ТМЭ 2010 он, №32
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай, ТМЭ 2017 он, №24
5. Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2017 он, №24
6. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, ТМЭ 1994 он, №2
7. Улсын бүртгэлийн ерөнхий хууль , ТМЭ 2018 он, №28
8. Үндэсний аюулгүй байдлын тухай, ТМЭ 2002 он, №3
9. Харьяатын тухай, ТМЭ 1995 он, №10-11
10. Монгол Улсын хилийн тухай хууль, ТМЭ 2016 он, №6
11. Хүн худалдаалахтай тэмцэх тухай, ТМЭ 2012 он, №7

ГУРАВ.ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. Журам шинэчлэн батлах тухай Монгол Улсын виз олгох журам/, ЗГ-ын 145 дугаар тогтоол, 2018 он.
2. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, ЗГ-ын 146 дугаар тогтоол, 2018 он.
3. Журам шинэчлэн батлах тухай /Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон МУ-д дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам/, ЗГ-ын 147 дугаар тогтоол, 2018 он.
4. Журам батлах тухай, Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам, ЗГ-ын 339 дүгээр тогтоол, 2010 он.
5. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам, Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоол.
6. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам/, ЗГ-ын 219 дүгээр тогтоол, 2015 он.
7. Жагсаалт батлах тухай/ Монгол Улсад визгүй зорчих гадаад улсын жагсаалт/, ЗГ-ын 186 дугаар тогтоол, 2014 он.
8. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай, ЗГ-ын 101 дүгээр тогтоол, 2014 он.
9. Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон

улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам, ЗГ-ын 97 дугаар тогтоол, 2012 он.
10. Хилийн боомтын жагсаалт батлахтухай, ЗГ-ын 4 дүгээр тогтоол, 2011 он.
11. Боомтуудын ерөнхий төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт батлах тухай, ЗГ-ын 102 дугаар тогтоол, 2010 он.
12. Журам батлах тухай, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыгтогтоох журам, ЗГ-ын 62 дугаар тогтоол, 2003 он.
13. Журамд нэмэлт оруулах тухай /Хилийн мэргэжлийн хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай/, ЗГ-ын 238 дугаар тогтоол, захирамж. 2001 он.

# ХАВСРАЛТ

**<u>Бүгд Найрамдах Хятад Ард улс</u>**

БНХАУ-тай харилцан визгүй зорчих гэрээ байгуулсан улс орнууд:

/2019 оны 06 сарын байдлаар/

- Armenia
- Azerbaijan
- Bangladesh
- Benin
- Bolivia
- Bosnia and Herzegovina[1]
- Burundi
- Comoros
- Congo
- Djibouti
- Eritrea
- Ethiopia
- Fiji[1]
- Gabon
- Georgia
- Grenada[1]
- Guinea
- Ivory Coast
- Mali
- Mauritania
- Mauritius[1]
- Moldova
- Mongolia[2]
- Nigeria
- North Korea[3]
- North Macedonia
- Pakistan
- Senegal
- Serbia[1]
- Seychelles[1]
- Singapore[1]
- Tajikistan
- Timor-Leste
- Togo
- Turkmenistan
- United Arab Emirates[1]
- Vietnam[4]
- Venezuela

Дараах жагсаалт дахь улс орны дипломат, албан, үйлчилгээний, онцгой, Епропын Холбооны төрийн албан хаагчийн паспорт эзэмшигч иргэд 2 улсын хооронд байгуулсан гэрээний дагуу БНХАУ-д 30 хүртэл хоног зорчих эрхтэй:

Тэмдэглэгээ:
D - дипломат паспорт
O - албаны паспорт
S - үйлчилгээний паспорт /service passport/
Sp - онцгой паспорт /special passport/
Lp - Епропын Холбооны төрийн албан хаагчийн паспорт /laissez-passers/

- All European Union citizens[1] D LP (conditional for Ireland and the United Kingdom)

- Afghanistan D
- Albania D S
- Algeria D S
- Angola D S
- Argentina D O
- Armenia D S
- Azerbaijan D S
- Bahamas D O
- Bahrain[2] D Sp
- Bangladesh D O
- Barbados D O
- Belarus D S
- Benin D S
- Bolivia D O
- Bosnia-Herzegovina D S
- Botswana D O
- Brazil D O
- Brunei D O
- Bulgaria D S
- Burkina Faso[2] D S
- Burundi D S
- Cambodia D S
- Cameroon D S
- Cape Verde D S
- Chile D O
- Colombia D O
- Comoros D O
- Congo D S
- Costa Rica D S
- Croatia D O S
- Cuba D O S
- Grenada D O
- Guinea D S
- Guyana D O
- Hungary D S
- Iceland D
- Indonesia D S
- Iran D S
- Iraq D
- *Ireland*[4] D O
- Israel D S
- Ivory Coast D S
- Jamaica D O
- Jordan D S Sp
- Kazakhstan D S
- Kenya D O
- Kuwait D Sp
- Kyrgyzstan D S
- Laos D O
- Lesotho D O
- Liberia D
- Lithuania D S
- Malaysia D O
- Maldives D S
- Mali[2] D S
- Malta D S
- Mauritania D S
- Mauritius D S
- Mexico D O
- Moldova D S
- Monaco[1] D
- Mongolia D S
- Peru D Sp
- Philippines D O
- Poland D S
- Romania D S
- Russia D S
- Rwanda D S
- Samoa D O
- San Marino[2] D S
- Sao Tome and Principe D S Sp
- Senegal D S
- Serbia D S
- Seychelles D S
- Sierra Leone D S
- Singapore D O
- Slovakia D S Sp
- Slovenia D S
- South Africa D S
- South Korea D O
- South Sudan D Sp
- Sri Lanka D O
- Sudan D O S
- Suriname D S
- Switzerland[2] D
- Tajikistan D S
- Tanzania D S
- Thailand D O
- Timor-Leste D S
- Togo D S
- Tonga D O
- Trinidad and Tobago D O
- Tunisia D Sp

- Cyprus D S
- Djibouti D S
- Dominica D O
- Ecuador D O S
- Egypt D Sp
- Equatorial Guinea D O Sp
- Eritrea[3] D S
- Ethiopia D S
- Fiji D S
- Gabon D S
- Gambia D O
- Georgia D S
- Ghana D S
- Grenada D O
- Montenegro D S
- Morocco[3] D S Sp
- Mozambique D S
- Myanmar D O
- Nepal D O
- Niger D S
- Nigeria D S
- North Korea D O
- North Macedonia D S
- Norway[1] D
- Oman D S Sp
- Pakistan D O
- Panama D S
- Papua New Guinea D S
- Turkey D S Sp
- Turkmenistan D S
- Ukraine D S
- United Arab Emirates D S
- *United Kingdom*[5] D O
- Uruguay D O S
- Uzbekistan D
- Venezuela D S
- Vietnam D S
- Zimbabwe D S

Түүнчлэн дараах улс орны иргэд 2 улсад бүртгэлтэй аяллын компаниар дамжин, аяллын групээр зорчиж байгаа тохиолдолд БНХАУ-д визгүй зорчино. Үүнд:

/2017 оны 4 сарын байдлаар/

1. Азербайжан
2. Гүрж
3. Молдав
4. Оросын Холбооны Улс
5. Туркменистан

БНХАУ-ын 2010 онд Хайнан арал руу шаардлага хангасан аяллын компаниар, груп аяллаар 15 хүртэл хоног визгүй зорчих 26 улсыг баталсан. Улмаар БНХАУ-ын Нийгмийн аюулгүй байдлын яам, Цагаачлалын алба 2018 оны 03 сарын 18-ны өдөр Хайнан арал руу визгүй зорчих улсуудын тоог 59 болгож, визгүй зорчих хоногийн тоог 59 болгосон. Дээрх 59 улсын иргэд групээр аялах шаардлагагүй болсон хэдий ч аль нэг аяллын компанид бүртгүүлж, аяллын төлөвлөгөө мэдэгдэж байхаар болсон. Үүнд доорх улс орнууд орно:

- All European Union citizens[1]
- Albania
- Argentina
- Australia
- Belarus[2]
- Bosnia and Herzegovina[2]
- Brazil
- Brunei
- Canada
- Chile
- Iceland
- Indonesia
- Japan[2]
- Kazakhstan
- Malaysia
- Mexico
- Monaco
- Montenegro
- New Zealand
- North Macedonia
- Norway
- Philippines
- Qatar[2]
- Russia
- Serbia[2]
- Singapore[2]
- South Korea
- Switzerland
- Thailand
- United Arab Emirates[2]
- Ukraine
- United States

Дэлгэрэнгүй мэдээлэл: http://www.xinhuanet.com/english/2018-04/18/c_137120441.htm

**<u>Япон Улс</u>**

Дэлхийн 68 улс орны иргэд Япон улсад визгүй зорчих эрхтэй. Үүнд:

Эх сурвалж: Япон Улсын Гадаад харилцааны яам /2019 оны 09 сарын байдлаар/

| **Asia** | **Europe** |
|---|---|
| Brunei (15 days) | Andorra |
| Indonesia | Austria |
| Malaysia | Belgium |
| Republic of Korea | Bulgaria |
| Singapore | Croatia |
| Thailand (15 days) | Cyprus |
| Hong Kong | Czech Republic |
| Macao | Denmark |
| Taiwan | Estonia |
| **North America** | Finland |
| Canada | Former Yugoslav Republic of Macedonia |
| United States | France |
| **Latin America and the Caribbean** | Germany |
| Argentina | Greece |
| Bahamas | Hungary |
| Barbados | Iceland |
| Chile | Ireland |
| Costa Rica | Italy |
| Dominican Republic | Latvia |

| **Asia** | **Europe** |
|---|---|
| El Salvador | Liechtenstein |
| Guatemala | Lithuania |
| Honduras | Luxembourg |
| Mexico | Malta |
| Surinam | Monaco |
| Uruguay | Netherlands |
| **Oceania** | Norway |
| Australia | Poland |
| New Zealand | Portugal |
| **Middle East** | Romania |
| Israel | San Marino |
| Turkey | Serbia |
| United Arab Emirates | Slovakia |
| **Africa** | Slovenia |
| Lesotho | Spain |
| Mauritius | Sweden |
| Tunisia | Switzerland |
| | United Kingdom |

## Бүгд Найрамдах Солонгос улс

Энгийн паспорт эзэмшигч дараах 112 улс орны иргэд БНСУ-д визгүй зорчих эрхтэй. Үүнд:

Эх сурвалж: http://english.visitkorea.or.kr /2019 оны 07 сарын байдлаар/

| Region | Country |
|---|---|
| **Asia** | Japan, Hong Kong, Macao, Taiwan, Brunei (30 Days), Singapore, Malaysia, Thailand |
| **Americas** | United States, Canada (6 Months), Guyana (30 Days), Guatemala, Grenada, Nicaragua, Dominican Republic, Dominica, Mexico, Barbados, Bahamas, Venezuela, Brazil, Saint Lucia, Saint Vincent & the Grenadines, Saint Kitts & Nevis, Suriname, Argentina, Haiti, Antigua & Barbuda, Ecuador, El Salvador, Honduras (30 Days), Uruguay, Jamaica, Chile, Costa Rica, Colombia, Trinidad & Tobago, Panama, Paraguay (30 Days), Peru |
| **Europe** | Andorra (30 Days), Monaco (30 Days), San Marino (30 Days), Cyprus (30 Days), Albania (30 Days), Croatia, Slovenia, Vatican (30 Days), Bosnia-Herzegovina (30 Days), Serbia, Montenegro (30 Days), Greece, Netherlands, Norway, Denmark, Germany, Latvia, Russia (60 Days / 90 Days total within a 180 day-period), Romania, Luxembourg, Lithuania, Lichtenstein, Malta, Belgium, Bulgaria, Sweden, Switzerland, Spain, Slovakia, Iceland, Ireland, Estonia, United Kingdom, Austria, Italy, Czech Republic, Kazakhstan (30 Days), Turkey, Portugal, Poland, France, Finland, Hungary |
| **Oceania** | Australia (30 Days), Guam (30 Days), Fiji (30 Days), Nauru (30 Days), Palau (30 Days), Kiribati (30 Days), Marshall Islands (30 Days), Solomon Islands (30 Days), Micronesia (30 Days), Samoa (30 Days), Tuvalu (30 Days), Tonga (30 Days), New Zealand |
| **Africa & Middle East** | Republic of South Africa (30 Days), Mauritius (30 Days), Seychelles (30 Days), Swaziland (30 Days), Botswana, Morocco, Saudi Arabia (30 Days), Arab Emirates, Oman (30 Days), Qatar (30 Days), Kuwait, Bahrain (30 Days), Liberia, Lesotho (60 Days), Israel, Tunisia (30 Days) |

Дипломат, албан паспорт эзэмшигч дараах 42 улс орны иргэд БНСУ-д визгүй зорчино. Үүнд:

| Passport type | Country |
|---|---|
| **Diplomatic & Official** | Indonesia (30 Days), Lebanon (30 Days), Gabon, Bolivia, Ukraine, Laos, Cyprus, Armenia, Japan, Mozambique, Argentina, Georgia, Moldova, Azerbaijan (30 Days), China (30 Days), Mongolia, Algeria, Cape Verde, Myanmar, Angola (30 Days), Cambodia (60 Days), Vanuatu, Oman, Croatia, Bangladesh, Kuwait, Kyrgyzstan (30 Days), Benin, Ecuador (Diplomatic: Duration of mission / Official: 3 Months), Tajikistan, Vietnam, Iran (3 Months), Paraguay, Belarus, Egypt, Pakistan (3 Months), Belize, India, Philippines (Unlimited) |
| **Diplomatic only** | Jordan, Uzbekistan (60 Days), Turkmenistan (30 Days) |

Дараах 24-өөс бусад бүх улс орны иргэд БНСУ-ын Жэжү арал руу 30 хүртэл хоног визгүй зорчино. Үүнд:

- Ghana, Nigeria, Macedonia, Sudan, Syria, Yemen, Afghanistan, Iran, Iraq, Kosovo, Cuba, Palestine, Gambia, Senegal, Bangladesh, Kyrgyzstan, Pakistan, Somalia, Uzbekistan, Nepal, Cameroon, Sri Lanka, Myanmar, Egypt.

## Тайландын Вант Улс

Тайландын Вант Улс руу (2019.05.01-ний байдлаар) дараах улс орны иргэд аялал жуулчлалын зорилгоор 30 хүртэл хоног визгүй зорчино.

## Summary of Countries and Territories entitled for Visa Exemption and Visa on Arrival to Thailand

| Ordinary Passport | | | | | | | Diplomatic/Official Passport | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Passport holders of the following countries/ territories may apply for Visa on Arrival | Passport holders of the following countries/ territories may enter Thailand without a visa | | | | | | Passport holders of the following countries/ territories may enter Thailand without a visa | | |
| | Tourist Visa Exemption Scheme | | | Bilateral Agreement | | | Bilateral Agreement | | |
| Period of stay | Period of stay | | | Period of stay | | | Period of stay | | |
| 15 days | 30 days | | | 14 days | 30 days | 90 days | 30 days | 90 days | |
| Bulgaria | Andorra | Norway | Brazil* | Cambodia | Hong Kong** | Argentina | Bangladesh (Diplomatic only) | Albania | Nepal |
| Bhutan | Australia | Oman | Korea (ROK)* | Myanmar (International Airports only) | Laos | Brazil* | Brunei | Argentina | Panama |
| China | Austria | The Philippines | Peru* | | Macau | Chile | Cambodia | Austria | Peru |
| Cyprus | Belgium | Poland | Hong Kong** | | Mongolia | Korea (ROK)* | China | Belarus | The Philippines |
| Ethiopia | Bahrain | Portugal | Vietnam** | | Russia (&VoA) | Peru* | Ecuador | Belgium | Poland |
| Fiji | Brunei | Qatar | | | Vietnam** | | Hong Kong | Bhutan | Romania |
| Georgia | Canada | San Marino | | | | | Indonesia | Brazil | Russia |
| India | Czech Republic | Singapore | | | | | Kazakhstan | Chile | Serbia |
| Kazakhstan | Denmark | Slovak | | | | | Laos | Colombia | Seychelles |
| Malta | Estonia | Slovenia | | | | | Macau | Costa Rica | Slovakia |
| Mexico | Finland | Spain | | | | | Malaysia | Croatia | South Africa |
| Nauru | France | South Africa | | | | | Mongolia | Czech Republic | Spain (Diplomatic only) |
| Papua New Guinea | Germany | Sweden | | | | | Myanmar | El Salvador | Sri Lanka |
| Romania | Greece | Switzerland | | | | | Oman | Estonia (Diplomatic only) | Switzerland |
| Saudi Arabia | Hungary | Turkey | | | | | Pakistan (Diplomatic only) | France (Diplomatic only) | Tajikistan |
| Taiwan | Iceland | Ukraine | | | | | Singapore | Germany | Tunisia |
| Uzbekistan | Indonesia | UAE | | | | | Vietnam | Georgia | Turkey |
| Vanuatu | Ireland | UK | | | | | | Hungary | Ukraine |
| | Israel | USA | | | | | | India | Uruguay |
| | Italy | | | | | | | Israel | |
| | Japan | | | | | | | Italy | |
| | Kuwait | | | | | | | Japan | |
| | Latvia | | | | | | | Korea (ROK) | |
| | Liechtenstein | | | | | | | Latvia | |
| | Lithuania | | | | | | | Liechtenstein | |
| | Luxembourg | | | | | | | Luxembourg | |
| | Malaysia | | | | | | | Mexico | |
| | Maldives | | | | | | | Montenegro | |
| | Mauritius | | | | | | | Morocco | |
| | Monaco | | | | | | | The Netherlands | |
| | The Netherlands | | | | | | | | |
| | New Zealand | | | | | | | | |

Department of Consular Affairs, 1 May 2019

**Remarks**

* Passport holders of Brazil, Republic of Korea and Peru are entitled for tourist visa exemption scheme. Meanwhile, Thailand also holds bilateral agreements on visa exemption for holders of diplomatic, official and ordinary passports for a visit of not exceeding 90 days with Brazil, Republic of Korea and Peru.

** Passport holders of Vietnam and Hong Kong are entitled for tourist visa exemption scheme. Meanwhile, Thailand also holds bilateral agreements on visa exemption for holders of diplomatic, official and ordinary passports for a visit of not exceeding 30 days with Vietnam and Hong Kong.

Ази, Номхон далайн бүсийн Вьетнам, Камбож, Киргиз зэрэг улс орнууд төрийн болон хувийн хэвшлийн цахим хуудсуудаар дамжуулан електрон визийг ажлын 4 цагаас 3 хоногт багтаан олгодог байна. Эдгээр нь 100 хувь онлайн үйлчилгээ бөгөөд визээ улсын хил дээр шууд олгодог байна.

**<u>Камбож</u>:**

Эх сурвалж: https://www.evisa.gov.kh/



**<u>Вьетнам</u>:**




Currency: USD
VISA FEES

| TYPE OF VISA | SERVICE FEE cost/pax Service (24 - 48 hours) | | | | Urgent (1 working day) | Super Urgent (4 hours) | Super Urgent (2 hours) | Super urgent (1 hour) | Non working time (during the holiday, at the weekend) | Guarantee service (15 minutes) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 - 2 | 3 - 5 | 6 - 9 | 10 - 1000 | | | | | | |
| 1 month single entry | 18 | 16 | 14 | 10 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |
| 3 months single | 30 | 25 | 20 | 15 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |
| 1 month multiple | 25 | 20 | 18 | 15 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |
| 3 months multiple (valids in 85 days) | 65 | 60 | 55 | 50 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |
| 6 months multiples (valids in 170 days) | 350 | 340 | 330 | 320 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |
| 1 year multiples | 560 | 550 | 540 | 530 | plus 10 | plus 30 | plus 50 | plus 110 | plus 180 | plus 220 |

Бүгд Найрамдах Киргиз Улс

Эх сурвалж: http://www.evisa.e-gov.kg/

